



**ИНД - 172**

Иргэний Нисэхийн Дүрэм

**Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт**

Иргэний нисэхийн ерөнхий газар

## **ДҮРМИЙН ТАЙЛБАР**

ИНД-172 нь Монгол Улсын Нислэгийн мэдээллийн бүсэд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлдэг байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлагыг тогтооно. Мөн энэ Дүрэм нь гэрчилгээжсэн байгууллага нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны болон техникийн стандартыг тогтооно.

**Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ нь дараах үйлчилгээнээс бүрдэнэ:**

- (1) аэродромын удирдлагын үйлчилгээ;
- (2) бүсийн удирдлагын үйлчилгээ;
- (3) ойртолтын удирдлагын үйлчилгээ;
- (4) нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (5) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (6) анхааруулах үйлчилгээ;
- (7) Даргын шаардлагатай гэж үзсэн, эсхүл иргэний нисэхийн системийн аюулгүй, үр дүнтэй үйл ажиллагаанд шаардлагатай бусад нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ.

**Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-172-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-172, түүний нэмэлт өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) веб сайтаас татаж авах боломжтой.**

**Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

<b>Өөрчлөлтийн дугаар</b>	<b>Хүчин төгөлдөр болсон огноо</b>
Анхны боловсруулалт	2002 оны 12 сарын 20
Нэмэлт өөрчлөлт 1	2003 оны 06 сарын 05
Нэмэлт өөрчлөлт 2	2010 оны 03 сарын 22
Нэмэлт өөрчлөлт 3 (Шинэчлэлт)	2019 оны ... сарын ...

**Тэмдэглэл:** ИНД-172-ын шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 172-ын 2018 оны 07 сарын 20-ны А.13-т үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>А Бүлэг - Ерөнхий зүйл</b> .....	<b>1</b>
172.1. Зорилго.....	1
172.3. Нэр томъёо болон товчлол .....	1
172.5. Гэрчилгээний шаардлага .....	1
172.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах.....	1
172.9. Гэрчилгээ олгох .....	1
172.11. Гэрчилгээний эрх.....	2
172.13. Гэрчилгээний хугацаа.....	2
172.15. Гэрчилгээ сунгах.....	2
<b>В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</b> .....	<b>3</b>
172.51. Ажилтанд тавих шаардлага .....	3
172.53. НХУ-ний сургалт .....	4
172.55. Ажлын болон үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалт.....	4
172.57. Байгууламжийн шаардлага.....	4
172.59. Үйлчилгээг хэрэгжүүлэх болон шилжүүлэх.....	7
172.61. Ээлжийн зохицуулалт .....	7
172.63. Баримт бичиг .....	7
172.65. Нөөц төлөвлөгөө .....	8
172.67. Зохицуулалтын шаардлага .....	8
172.69. Байгууламжийн төлөв байдлыг мэдээлэх.....	9
172.71. Нислэгийн мэдээллийн ерөнхий шаардлага .....	10
172.73. Цаг уурын мэдээлэл болон түүнийг мэдээлэх.....	10
172.75. Бүсийн болон ойртолтын удирдлагын үйлчилгээ.....	11
172.77. Аэродромын удирдлагын үйлчилгээ .....	12
172.79. Тусгай зориулалтаар ашиглах агаарын зай .....	13
172.81. Хяналтын хариуцлага.....	14
172.83. Давуу эрх.....	14
172.85. Хөдөлгөөний урсгал зохицуулалт.....	16
172.87. НХУ-ын зөвшөөрөл.....	16
172.89. Аяллын түвшин.....	17
172.91. НХУ-ын зөвшөөрлөөс хазайх.....	17
172.93. Нислэгийн мэдээллийн үйлчилгээ.....	17
172.95. Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ .....	19
172.97. Анхааруулах үйлчилгээ.....	19
172.99. Нислэгийн төлөвлөгөө.....	22
172.101. Цаг .....	23
172.103. Алтиметрийн тохируулга хийх журам .....	23
172.105. Радио болон утсан холбооны журам .....	23
172.107. НХУ-ний ажиглалтын үйлчилгээ .....	24
172.109. Агаарын хөлгийн онцгой нөхцөлийн болон хэвийн бус үйл ажиллагаа .....	24
172.111. Ноцтой зөрчил, эсхүл ослын дараах арга хэмжээ .....	25
172.113. Зөрчил.....	25
172.115. Бүртгэл .....	25
172.117. Бүртгэлийн дэвтэр болон үйл ажиллагааны нэгжийн дэвтэр .....	27
172.119. Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр.....	27
172.121. Үйлчилгээний тасралт .....	28
172.123. Аюулгүй байдлын удирдлага .....	28
172.125. НХУБ-ын Ерөнхий заавар .....	29

<b>С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага .....</b>	<b>31</b>
172.151. Байнгын хэрэгжилт .....	31
172.153. Үйл ажиллагааны заавар .....	31
172.155. Туршилт .....	32
172.157. НХУ-ын зөвшөөрөл олгохоос татгалзах.....	32
172.159. VFR нислэгийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх .....	32
172.161. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт .....	32
172.163. Үйлчилгээг зогсоох, эсхүл шилжүүлэх .....	33
172.165. Аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөр.....	33
<b>D Бүлэг - Бусад НХУ .....</b>	<b>34</b>
172.201. Ерөнхий зүйл .....	34
172.203. Гэрчилгээний шаардлага .....	34
172.205. Хүсэлт гаргах .....	34
172.207. Гэрчилгээ олгох .....	34
172.209. Үйл ажиллагааны нөхцөл.....	35
<b>E Бүлэг - Зайчлалын шалгуур болон минима .....</b>	<b>35</b>
172.251. Босоо зайчлал .....	35
172.253. Хосолмол ил харааны зайчлал .....	35
172.255. Аэродромын ойролцоох бүсийн гаднах ил харааны зайчлал .....	35
172.257. Тууш зайчлалыг хугацаагаар тогтоох .....	36
172.259. Тууш зайчлалыг зайгаар тогтоох.....	36
172.261. Хажуугийн зайчлал.....	36
172.263. Хэрэглэлийн ойртолтын үеийн агаарын хөлөг хоорондын зайчлал .....	37
172.265. НХУ-ний ажиглалтын үйлчилгээгээр хангах үеийн багасгасан зайчлал .....	37
172.267. НХУ-ний ажиглалтын үйлчилгээгээр танигдаагүй хяналттай нислэгээс зайчлах. .....	37
172.269. НХУ-ний ажиглалтын үйлчилгээний хүлээлтэд байгаа агаарын хөлгөөс зайчлах .....	37
172.271. Жагсаалын нислэг .....	38
172.273. ХБЗ-ны багасгасан зайчлалын ерөнхий шаардлага .....	38
172.275. Нисэн гарах нислэг хоорондын ХБЗ-ны багасгасан зайчлал .....	38
172.277. Нисэн ирэх, нисэн гарах нислэг хоорондын ХБЗ-ны багасгасан зайчлал.....	38
172.279. Нисэн ирэх нислэг хоорондын ХБЗ-ны багасгасан зайчлал.....	39
172.281. Зэрэгцээ ХБЗ-ны үйл ажиллагаа .....	39
172.283. Агаарт түлш юүлэх агаарын хөлгийн зайчлал.....	39
172.285. Цэргийн агаарын хөлгийн зайчлал.....	40
172.287. Нисэн гаргах IFR нислэг хоорондын зайчлал.....	40
172.289. Нисдэг тэрэг болон хөдөлгүүргүй агаарын хөлөг .....	40
172.291. Дагалдах хуйлралын зайчлал.....	40
172.293. Идэвхтэй байгаа тусгай зориулалтаар ашиглах агаарын зайн зайчлал.....	41
<b>F Бүлэг - Стандарт хэвшмэл хэллэг .....</b>	<b>41</b>
172.351. Хамрах хүрээ .....	41
172.353. Нислэгийн хөдөлгөөний удирдагч болон нисгэгч хоорондын хэвшмэл хэллэг	42
172.355. НХУ-ний зохицуулалтын хэвшмэл хэллэг .....	43
<b>G Бүлэг - НХУ-ний ажиглалтын журам.....</b>	<b>44</b>
172.401. Транспондериин түвшний мэдээллийг бататгах .....	44
172.403. Хурдны хяналт .....	44
<b>H Бүлэг - Шилжилтийн зохицуулалт.....</b>	<b>45</b>
172.451. НХУБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилт .....	45
172.453. НХУБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт . .....	46

## Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт

### А Бүлэг - Ерөнхий зүйл

#### 172.1. Зорилго

(a) Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) Монгол Улсын FIR-д НХҮ үзүүлдэг байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны;
- (2) тухайн байгууллагын НХҮ үзүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны болон техникийн стандарт.

(b) А, В болон С Бүлэг нь 172.11(a)(1) - (6)-д заасан НХҮ-нд хамаарна.

(c) D Бүлэг нь 172.11(a)(7)-д заасан НХҮ-нд хамаарна.

#### 172.3. Нэр томьёо болон товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.

#### 172.5. Гэрчилгээний шаардлага

Аливаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын (цаашид “НХҮБ” гэх) гэрчилгээний эрхийн хүрээ болон хязгаарлалтад заагаагүй НХҮ-г үзүүлэхгүй байх үүрэгтэй.

#### 172.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлага хангасан байна:

- (1) дараах мэдээллийг шаардсан САА 24172/01 маягтыг бөглөх:
  - (i) хүсэлт гаргагчийн нэр болон Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хаяг;
  - (ii) тусгай НХҮ, эсхүл үзүүлэх НХҮ;
  - (iii) тухайн үйлчилгээг үзүүлэх аэродромын байрлал, эсхүл тогтоосон агаарын зай;
  - (iv) тухайн хүсэлт гаргагч болон төлөвлөсөн үйлчилгээтэй холбоотой маягтад заасан, Даргын шаардаж болох бусад мэдээлэл;
- (2) гүйцэд бөглөсөн маягтыг дараах баримт бичгийн хамт Даргад хүргүүлэх:
  - (i) 172.125-д шаардсан Ерөнхий заавар;
  - (ii) зохих төлбөрийн баримт.

#### 172.9. Гэрчилгээ олгох

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл тухайн хүсэлт гаргагч нь НХҮБ-ын гэрчилгээ эзэмших эрхтэй:

- (1) хүсэлт гаргагч В Бүлэгт заасан шаардлагыг хангасан байх;

- (2) хүсэлт гаргагч болон 172.51-д шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүн байх;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

(b) Дарга, нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс тухайн ижил НХҮ-ний хувьд, аль ч цаг хугацаанд зөвхөн нэг гэрчилгээ хүчинтэй байдаг болохыг бататгана.

#### **172.11. Гэрчилгээний эрх**

(a) НХҮБ-ын гэрчилгээнд, дараах аль НХҮ болон тухайн үйлчилгээний аль сургалт, үнэлгээг тухайн гэрчилгээ эзэмшигчид хийж гүйцэтгэхийг зөвшөөрсөн болохыг заана:

- (1) бүсийн удирдлагын үйлчилгээ;
- (2) ойртолтын удирдлагын үйлчилгээ;
- (3) аэродромын удирдлагын үйлчилгээ;
- (4) нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (5) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (6) анхааруулах үйлчилгээ;
- (7) D Бүлгийн дагуу үзүүлэх аливаа бусад үйлчилгээ.

(b) НХҮБ-ын гэрчилгээ нь:

- (1) тухайн үйлчилгээг үзүүлэх аэродром, эсхүл агаарын зайг заана;
- (2) Даргын шаардлагатай гэж үзсэн нөхцөлийг багтаасан байж болно.

#### **172.13. Гэрчилгээний хугацаа**

(a) НХҮБ-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.

(b) НХҮБ-ын гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.

(c) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон тохиолдолд гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.

(d) Гэрчилгээг түдгэлзүүлсэн тохиолдолд НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлнэ.

#### **172.15. Гэрчилгээ сунгах**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24172/01 маягтын дагуу гаргах ёстой.

(b) Хүсэлтийг тухайн гэрчилгээнд заасан сунгах хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацааг заагаагүй бол тухайн гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

## В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

### 172.51. Ажилтанд тавих шаардлага

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

- (1) байгууллагын Ерөнхий зааварт заасан НХҮ бүрийг дараах байдлаар гүйцэтгэхээ тухайн хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах үүрэгтэй, Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон удирдах ажилтан:
  - (i) санхүүжүүлж чаддаг байх;
  - (ii) энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу үзүүлдэг байх;
- (2) дараах үйл ажиллагааны чиглэлээр Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх удирдах ажилтан, эсхүл ажилтнууд:
  - (i) хүсэлт гаргагчийн байгууллага нь энэ Дүрмийн шаардлага хангаж байгааг бататгах;
  - (ii) 172.123-т шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;
- (3) Ерөнхий заавартаа заасан НХҮ болон холбогдох сургалт, эсхүл үнэлгээ хийх ажиллагааг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх болон гүйцэтгэх хангалттай тооны ажилтан.

(аа) Энэ зүйлийн (а)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвар, туршлагаа харуулсан байх үүрэгтэй.

(б) Хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) тухайн хүсэлт гаргагчаас, Ерөнхий заавартаа заасан НХҮ болон үйлчилгээний сургалт, үнэлгээг хийх эрх олгосон ажилтны ур чадварыг бататгах;
- (2) дээрх ажилтанд, түүний эрхийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох;
- (3) эрх бүхий ажилтан энэ Хууль болон ИНД-65-ын дагуу олгосон зохих, хүчинтэй үнэмлэх болон зэрэглэл эзэмшдэг болохыг бататгах;
- (4) боломжтой бүх тохиолдолд, тухайн эрх бүхий ажилтан нь хэрэв тэд бүх холбогдох, хүчинтэй мэдээллийг ашигладаг ба мэддэг бол, зөвхөн өөрийн эзэмшдэг зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлдэг болохыг бататгах;
- (5) зэрэглэлтэй НХҮ-ний үнэмлэх эзэмшигчийн хувьд, ИНД-65-ын туршлага хадгалах шаардлагын хэрэгжилтийг хялбаршуулах;
- (6) боломжтой бүх тохиолдолд, нислэгийн хөдөлгөөний удирдагч нь тухайн зэрэглэлийн эрхийг дараах тохиолдолд хэрэгжүүлдэггүй болохыг бататгах:
  - (i) ЭМГ-ний аливаа нөхцөлийг хангаагүй;
  - (ii) эрүүл мэндийн байдлын аливаа өөрчлөлт нь тэднийг эрхээ аюулгүй хэрэгжүүлэх чадамжгүй болгож болох.



**172.53. НХҮ-ний сургалт**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтны сургалтын болон үнэлгээ хийх журам, хөтөлбөрийг боловсруулсан байна:

- (1) нислэгийн хөдөлгөөний удирдагч;
- (2) нислэгийн мэдээллийн ажилтан;
- (3) HF нисэхийн холбооны үйлчилгээний хангалтад шууд оролцдог ажилтан;
- (4) дараах ажилтныг дэмжих ажиллагаанд шууд оролцдог ажилтан:
  - (i) зэрэглэлтэй нислэгийн хөдөлгөөний удирдагч;
  - (ii) зэрэглэлтэй нислэгийн мэдээллийн ажилтан.

(b) Хүсэлт гаргагч нь, үйл ажиллагааны орчинд зааварчилгаа өгч байгаа ажилтныг ИНД-65-ын дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний Багшийн зэрэглэл эзэмшдэг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

(c) Хүсэлт гаргагч нь үнэмлэх олгох, эсхүл зэрэглэл олгох, эсхүл зэрэглэлийг хүлээн зөвшөөрөх зорилгоор үнэлгээ хийж байгаа ажилтныг ИНД-65-ын дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний Багшийн, эсхүл Шалгагчийн зэрэглэл эзэмшдэг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

**172.55. Ажлын болон үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалт**

[Нөөц]

**172.57. Байгууламжийн шаардлага**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан НХҮ-нд тохирсон дараах байгууламжийг бүрдүүлсэн байх үүрэгтэй:

- (1) аэродромын удирдлагын цамхаг;
- (2) ойртолтын удирдлагын байр;
- (3) бүсийн удирдлагын төв;
- (4) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний байр;
- (5) нислэгийн мэдээллийн үйлчилгээний төв;
- (6) сургалт болон үнэлгээ хийх зориулалтын байгууламж.

(b) Энэ зүйлийн (h)-д зааснаас бусад тохиолдолд, аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргагч нь түр цамхаг, эсхүл байрыг багтаасан, Ерөнхий заавартаа заасан аэродромын удирдлагын цамхаг, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний байрыг дараах шаардлага хангасан болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) дараах нөхцөлийг хангахаар байгуулсан ба байрлуулсан байх:
  - (i) тухайн аэродромын нислэгийн хөдөлгөөний максимум боломжит алсын барааны харагдацтай байх;
  - (ii) гэрлийн гялбалт болон ойлтоос хамгаалсан байх;
  - (iii) дуу чимээнээс хамгаалсан байх;
- (2) энэ зүйлийн (b)(1)-ийн нөхцөлд нөлөөлөх аливаа бүтээн байгуулалтын ажлаас хамгаалсан байх;

- (3) ганц ажилтантай хяналтын байр нь дараах шаардлага хангасан байх:
- (i) НХҮ-г аль болох тасалдуулахгүй, эсхүл бууруулахгүй байхыг бататгах ариун цэврийн өрөөтэй байх;
  - (ii) ил харааны хяналтын байранд хоол хүнс, ундаа хадгалах болон бэлтгэх байртай байх;
- (4) дараах хоёр талын дуут холбооны төхөөрөмжөөр тоногдсон байх:
- (i) тухайн хүсэлт гаргагчийн хариуцсан агаарын зайд, эсхүл түүний зэргэлдээх агаарын зайд байгаа агаарын хөлөгтэй холбоо барих;
  - (ii) маневрын талбай, эсхүл түүний зэргэлдээх талбайд байгаа агаарын хөлөг, тээврийн хэрэгсэл болон хүнтэй холбоо барих;
- (5) дараах минимум төхөөрөмжөөр тоногдсон байх:
- (i) бодит болон хүлээгдэж байгаа аэродромын нислэгийн хөдөлгөөний төлөв байдлыг тухайн агаарын хөлгийн нэмэлт мэдээллийн хамт харуулах зорилгоор бүтээгдсэн дэлгэцийн систем, эсхүл системүүд;
  - (ii) цахилгаан хангамж;
  - (iii) тохирох, хүчинтэй газрын зураг болон нислэгийн зураг;
  - (iv) 2 нүдний дуран;
  - (v) цаг;
  - (vi) бүртгэл хадгалах систем;
  - (vii) гаднах агаарын хэм заах хэрэглэл;
  - (viii) QNH дэлгэц;
  - (ix) улаан, ногоон болон цагаан өнгийн дохионы гэрэл;
  - (x) утсан холбоо;
  - (xi) ойртолтын болон буултын туслах хэрэгсэл, тухайн ХБЗ-ыг ашиглахад нөлөөлдөг авто зам, эсхүл төмөр замын дохионы төхөөрөмжийн төлөв байдлыг хянах төхөөрөмж;
  - (xii) алсын барааны харагдац болон үүлний доод суурийн өндрийг хянах цэг;
  - (xiii) дуу чимээ бичих, хэрэв хамааралтай бол өгөгдөл бичих төхөөрөмж;
  - (xiv) салхины чиглэл болон салхины хурд заах дэлгэц;
  - (xv) ослыг анхааруулах дуут систем;
  - (xvi) AFS терминал, эсхүл хэрэв НХҮ-ний гэрээнд заасан бол, хэвийн үед AFS-ээр дамжуулдаг мэдээллийг хүлээн авах болон дамжуулах өөр орлох төхөөрөмж;
  - (xvii) хэрэв хамааралтай бол, нислэгийн зурвасны гэрэлтүүлгийг удирдах дэлгэц;
- (6) ил харааны хяналтын байранд суурилуулсан анеройдын барометр, эсхүл барометрийн алтиметрийн аль нэг нь байх ёстой ба хүчинтэй алтиметрийн тохируулгыг үл хамаарах хоёр эх үүсвэрээр хангасан байх.
- (c) Хүсэлт гаргагч, бүсийн удирдлагын төв, нислэгийн мэдээллийн төв болон ойртолтын удирдлагын байр нь дараах шаардлага хангасан болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:
- (1) дараах боломжийг олгодог төхөөрөмжөөр тоногдсон байх:
- (i) өргөн боломжтой хоёр талын дуут холбоо тогтоох;
  - (ii) хэрэв хамааралтай бол, тухайн хүсэлт гаргагчийн хариуцсан агаарын зайд, эсхүл зэргэлдээх агаарын зайд байгаа агаарын хөлөгтэй тоон өгөгдлийн холбоо тогтоох.

(2) дараах минимум төхөөрөмжөөр тоногдсон байх:

- (i) бодит болон хүлээгдэж байгаа нислэгийн төлөв байдлыг тухайн агаарын хөлгийн нэмэлт мэдээллийн хамт харуулах зорилгоор бүтээгдсэн дэлгэцийн систем, эсхүл системүүд;
- (ii) цахилгаан хангамж;
- (iii) тохирох, хүчинтэй газрын зураг болон нислэгийн зураг;
- (iv) цаг;
- (v) бүртгэл хадгалах систем;
- (vi) навигацийн, ойртолтын болон буултын туслах хэрэгслийн ажиллагааг хянах төхөөрөмж;
- (vii) утсан холбоо;
- (viii) дуу чимээ бичих, хэрэв хамааралтай бол өгөгдөл бичих төхөөрөмж;
- (ix) AFS терминал;
- (x) ойртолтын удирдлагын үйл ажиллагааны нэгжийн хувьд, тухайн аэродромын ойртолтын процедурын удирдлагын, эсхүл ойртолтын ажиглалтын-удирдлагын үйл ажиллагааны нэгжийн ILS/MLS-ийн төлөв байдлыг хянах дэлгэц;
- (xi) төгсгөлийн ойртолт, эсхүл агаарын хөлгийн буулт, эсхүл хөөрөлт хариуцсан ойртолтын удирдлагын үйл ажиллагааны нэгжид, аэродромын удирдлагын цамхагт ашиглаж байгаа төхөөрөмжтэй ижил эх үүсвэрээр тэжээгддэг салхины чиглэл болон салхины хурд заах дэлгэц.

(d) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (b) болон (c)-д шаардсан нисэхийн холбооны төхөөрөмжийг ИНД-171-д заасны дагуу ажилладаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(e) Хүсэлт гаргагч нь НХҮ-нд ашиглах аливаа ил хараагаар ажиглах дэлгэцийг, тухайн дэлгэцээр үзүүлж байгаа мэдээллийн ач холбогдлыг тооцон, холбогдох ажилтан хэрэглэхэд хялбар байхаар байрлуулсан болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(f) Энэ зүйлийн (b)(4), (5) болон (c)(1), (2)-т шаардсан төхөөрөмж нь үзүүлэлтийн татгалзал, бүрэн бус байдал, эсхүл их хэмжээний бууралтын боломжийг багасгах зорилгоор найдвартай ажиллагааны, хэрэглээний бэлэн байдлын болон нөөцлөлийн түвшинтэй байх ёстой.

(g) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (b)(5)(xi), (c)(2)(vi) болон (x)-т шаардсан, төлөв байдлыг хянах төхөөрөмжийг дараах төхөөрөмжөөр тоногдсон болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) төлөв байдлын өөрчлөлтийг мэдээлэх дуут дохио;
- (2) бодит төлөв байдлыг нүдэнд ил харагдахаар мэдээлэх.

(h) Хэрэв хийхэд тохиромжгүй бөгөөд бусад шаардлагатай арга хэмжээг авсан бол, түр аэродромын удирдлагын цамхаг болон түр аэродромын нислэгийн мэдээллийн байрыг энэ зүйлийн (b)(5)(xi), (xvi) болон (xvii)-д шаардсан төхөөрөмжөөр тоногдсон байхыг шаардахгүй, тухайлбал:

- (1) түр цамхаг, эсхүл түр байрнаас НХҮ үзүүлж байгаа этгээдийг, энэ зүйлийн (b)(5)(xi) болон (xvi)-д шаардсан төхөөрөмжөөс авч хэрэглэх боломжтой мэдээллээр хангах;
- (2) хэрэв хамааралтай бол, нислэгийн зурвасны гэрэлтүүлгийг хянах.

#### **172.59. Үйлчилгээг хэрэгжүүлэх болон шилжүүлэх**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь өөрийн хүсэлтэд дараах мэдээллийг багтаасан байна:

- (1) аэродром болон агаарын зай бүрийн хувьд, үйл ажиллагааны эхний 12 сард санал болгож байгаа үйлчилгээний цагийн хуваарь;
- (2) одоогийн байдлаар НХҮ үзүүлдэггүй аэродром, эсхүл агаарын зайн хувьд, гэрчилгээ авахаас өмнө тооцож үзсэн аюулгүй байдлын хүчин зүйлийн хураангуй мэдээлэл.

(b) Үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа гэрчилгээ эзэмшигчээс НХҮ үзүүлэх хариуцлагыг шилжүүлэн авахаар зорьж байгаа НХҮ-ний гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь өөрийн хүсэлтэд тухайн хоёр байгууллагын Гүйцэтгэх захирлын баталгаажуулсан шилжилтийн зохицуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан байна.

#### **172.61. Ээлжийн зохицуулалт**

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) ээлжийн эхлэл болон төгсгөлд, дараах ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай, хангалттай цаг хугацаагаар хангадаг болохыг:
  - (i) НХҮ үзүүлж эхлэхээс өмнөх;
  - (ii) НХҮ үзүүлэх ажиллагаа дууссаны дараах;
- (2) НХҮ-ний үйл ажиллагааны нэгжид хийж байгаа хяналт бүрийг шилжүүлэхэд минимум 5 минут зарцуулдаг байх.

#### **172.63. Баримт бичиг**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан үйлчилгээний хангалт болон үйл ажиллагаанд шаардагдах, холбогдох техникийн заавар болон бусад бүх баримт бичгийн хувийг хадгалсан байх үүрэгтэй.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-д шаардсан бүх баримт бичгийг хянах журмыг тогтоосон байх үүрэгтэй. Энэ журам нь дараах шаардлагыг бататгах ёстой:

- (1) бүх ирсэн баримт бичгийг эрх бүхий ажилтан хянаж, шаардлагатай арга хэмжээ авдаг байх;
- (2) бүх баримт бичгийг боловсруулж гаргахаас өмнө холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;
- (3) НХҮ-гээр хангах болон үйл ажиллагаа гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох бүх баримт бичгийн хүчинтэй хувийг, тухайн баримт бичиг шаардлагатай бүх байрлалд ажилтан авч ашиглахад бэлэн байлгах;

- (4) хүчингүй болсон баримт бичгийг боловсруулж гаргасан, эсхүл ашиглаж байгаа цэг бүрээс нэн даруй хураан авдаг байх;
- (5) архивд хадгалж байгаа хүчингүй болсон баримт бичгийн хүчингүй болохыг хялбар таньж тогтоодог байх;
- (6) хянах болон зөвшөөрөл олгохын өмнө холбогдох лавлах мэдээллийг авч ашиглах эрх бүхий этгээд тухайн баримт бичгийн өөрчлөлтийг хянаж, зөвшөөрдөг байх;
- (7) хугацаа нь дууссан хэвлэлтийг ашиглахаас сэргийлж баримт бичгийн хуудас бүрийн хүчинтэй хувилбарыг таньж тогтоож болдог байх.

#### **172.65. Нөөц төлөвлөгөө**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ, эсхүл холбогдох дэмжих үйлчилгээ тасрах, тасалдах, эсхүл түр зогсох тохиолдолд аюулгүй, дэс дараатай нислэгийн хөдөлгөөний урсгалаар хангах зорилготой нөөц төлөвлөгөө боловсруулсан байна.

#### **172.67. Зохицуулалтын шаардлага**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэв хамааралтай бол, Ерөнхий заавартаа заасан НХҮ-ний нэгж болон дараах байгууллага хоорондын зохицуулалтыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) ИНД-171-ийн дагуу олгосон АНТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч;
- (2) ИНД-173-ын дагуу олгосон ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмшигч;
- (3) ИНД-174-ийн дагуу олгосон НЦҮҮБ-ын гэрчилгээ эзэмшигч;
- (4) ИНД-175-ын дагуу олгосон НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч;
- (5) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч;
- (6) Монгол Улсын Зэвсэгт хүчин;
- (7) эрэн хайх, авран туслах байгууллага;
- (8) хэрэв заасан НХҮ-ний нэгж нь аэродромын удирдлагын, эсхүл аэродромын НМҮ-ний нэгж бол:
  - (i) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч;
  - (ii) хэрэв тухайн үйлчилгээг аэродромын удирдлагын үйлчилгээний нэгж үзүүлдэггүй бол, апрон зохицуулалтын үйлчилгээ.

(b) Хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан НХҮ-ний нэгжүүдийн хооронд болон дараах НХҮ-ний нэгжтэй НХҮ-ний гэрээ байгуулсан болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) зэргэлдээх агаарын зайг хариуцсан НХҮ-ний нэгж;
- (2) үйл ажиллагааны зохицуулалтыг тогтмол хийх шаардлагатай бусад НХҮ-ний нэгж.

(c) Хүсэлт гаргагч нь НХҮ-ний гэрээ дараах шаардлага хангасан болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) тухайн гэрээнд оролцогч үйлчилгээний нэгж хоорондын үр дүнтэй зохицуулалтад шаардлагатай асуудлыг дэлгэрэнгүй тусгасан байх;
  - (2) хүчинтэй байдлаар нь хадгалдаг байх;
  - (3) оролцогч үйлчилгээний нэгж бүрийн эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурсан байх;
  - (4) тухайн хүсэлт гаргагчийн үйл ажиллагааны зааврын салшгүй хэсэг байх.
- (d) Хүсэлт гаргагч нь, үйл ажиллагааны шаардлагаар хоорондоо холбоотой байдаг НХҮ-ний нэгж хоорондын харилцаа холбоог хялбаршуулах тогтолцоо болон журмаар хангасан байх үүрэгтэй.
- (e) Хүсэлт гаргагч нь НХҮ-ний нэгж, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон НЦУҮБ-ыг, хэрэв тэд тухайн мэдээллийг шаарддаг бол, НХҮ-ний мэдээ солилцох замаар дараах дэлгэрэнгүй мэдээллээр хангадаг болохыг бататгах тогтолцоо болон журмаар хангасан байх үүрэгтэй:
- (1) нислэгийн төлөвлөгөө хүргүүлсэн агаарын хөлөг бүрийн төлөвлөсөн нислэгийн хөдөлгөөн болон тухайн нислэгийн төлөвлөгөөнд орсон аливаа нэмэлт өөрчлөлт;
  - (2) тухайн нислэгийн бодит явцын талаарх хүчинтэй мэдээлэл.
- (f) Хүсэлт гаргагч нь CAVOK нэр томъёог хэрэглэхгүй байх ёстойгоос бусад тохиолдолд, Doc 4444 (Part IX - Air Traffic Services Messages)-т заасан журмын дагуу НХҮ-ний мэдээг бэлтгэж, түгээдэг ба харилцан ишлэл хийдэг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

#### **172.69. Байгууламжийн төлөв байдлыг мэдээлэх**

- (a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, Ерөнхий заавартаа заасан байгууламж, эсхүл үйлчилгээ бүрийн үйл ажиллагааны төлөв байдлын өөрчлөлт болон холбогдох үйл ажиллагааны мэдээллийг НХҮ-ний хэрэглэгчдэд мэдээлэх журмыг тогтоосон байх үүрэгтэй.
- (b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-ийн дагуу тогтоосон журам дараах шаардлагыг хангасан болохыг бататгах үүрэгтэй:
- (1) хүсэлт гаргагчийн НХҮ бүрийн үйл ажиллагааны мэдээллийг, AIP үйлчилгээ үзүүлэх зорилгоор ИНД-175-ын дагуу олгосон НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигчид дамжуулдаг байх;
  - (2) хүсэлт гаргагчийн НХҮ-ний хэрэглэгчдэд, агаарын навигацийн аюулгүй байдалд нөлөөлж болох байгууламжийн, эсхүл үйлчилгээний үйл ажиллагааны төлөв байдлын аливаа өөрчлөлтийг цаг алдалгүй мэдээлдэг байх ба хэрэв тухайн өөрчлөлт нь түр шинж чанартай байхаас бусад тохиолдолд, тухайн үйл ажиллагааны төлөв байдлын аливаа өөрчлөлттэй холбоотой мэдээллийг NOTAM үйлчилгээнд зориулж НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигчид хүргүүлдэг байх.

**172.71. Нислэгийн мэдээллийн ерөнхий шаардлага**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч тухайн ажиллагаа нь хүсэлт гаргагчийн хариуцлагын бүсэд нислэгт ашиглаж байгаа агаарын зайд нөлөөлөх тохиолдолд, дараах мэдээллийг хүлээн авах журмыг тогтоосон байна:

- (1) дэлбэрэхийн өмнөх галт уулын идэвхжил;
- (2) галт уулын дэлбэрэлт;
- (3) галт уулын үнсэн үүл;
- (4) атмосферт цацраг идэвхт материал, эсхүл хорт бодис цацагдах.

(b) Хүсэлт гаргагч нь үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөж байгаа хариуцлагын бүсэд хамаарах НХҮ-ний нэгж бүрийг дараах төхөөрөмжийн үйл ажиллагааны төлөв байдлын мэдээллээр тогтмол хангадаг болохыг бататгах тогтолцоо болон журмыг тогтоосон байна:

- (1) ил харааны бус навигацийн туслах төхөөрөмж;
- (2) хөөрөлт, нисэн гарах, ойртолт болон буулт үйлдэх журмыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай ил харааны туслах хэрэгсэл;
- (3) гадаргуу дээрх хөдөлгөөнд зайлшгүй шаардлагатай ил харааны болон ил харааны бус туслах хэрэгсэл.

(c) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үйлчилгээний нэгжийг тухайн хөдөлгөөнт бүсийн онцгой нөхцөлийн мэдээллээр тогтмол хангадаг болохыг бататгах журмыг тогтоосон байна. Мэдээлэлд тухайн аэродромын холбогдох байгууламжийн үйл ажиллагааны төлөв байдал болон оршин байгаа түр шинжтэй аюулын мэдээллийг багтаасан байна:

- (1) аэродромын удирдлагын үйлчилгээний нэгж; эсхүл
- (2) ойртолтын удирдлагын үйлчилгээний нэгж; эсхүл
- (3) аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний нэгж.

**172.73. Цаг уурын мэдээлэл болон түүнийг мэдээлэх**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, дараах бүх цаг уурын мэдээллийг нислэгийн мэдээллийн үйлчилгээний нэг хэсгийн адил хангадаг болохыг бататгах тогтолцоо болон журмыг тогтоосон байна:

- (1) ИНД-174-ийн дагуу олгосон НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн хангасан; эсхүл
- (2) ИНД-174.3 болон 174.6-гийн дагуу гаргасан үндсэн цаг агаарын мэдээ.

(b) Хүсэлт гаргагч нь, НХҮ-ний нэгжүүдийг тэдний хариуцсан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай цаг уурын мэдээллээр, НХҮ-ний ажилтан ашиглахад минимум ажиллагаа шаарддаг хэлбэрээр хангадаг болохыг бататгах тогтолцоо болон журмыг тогтоосон байна.

(c) Хүсэлт гаргагч нь, цаг агаарын үндсэн мэдээ бүрдүүлэхэд ашигладаг төхөөрөмж дараах шаардлага хангасан болохыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) тухайн хэмжилт шаардлагатай бүсийг төлөөлөх өгөгдлөөр хангадаг байх;

(2) тухайн төхөөрөмж нь хэд хэдэн салхины чиглэл болон хурд заагчаас бүрддэг тохиолдолд, хэрэгсэл бүрийн хяналт тавьдаг ХБЗ, эсхүл ХБЗ-ны хэсгийг тодорхойлдог байх.

(d) Хүсэлт гаргагч нь, цаг уурын мэдээнд агуулагдсан мэдээллийг тухайн мэдээллийг дамжуулах хүртэл өөрчлөгдөөгүй хэвээр байгааг бататгах журмыг тогтоосон байна.

### **172.75. Бүсийн болон ойртолтын удирдлагын үйлчилгээ**

(a) Бүсийн, эсхүл ойртолтын удирдлагын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үйл ажиллагааг зохицуулах тогтолцоо болон журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) хүлээн авсан мэдээллээр мэдэгдэж байгаа агаарын хөлөг хоорондын хамаарах байршлыг тогтоох;
- (2) тухайн үйлчилгээний нэгжийн хяналтад байгаа агаарын хөлөг хоорондын ойртолтоос сэргийлэх болон аюулгүй, үр дүнтэй нислэгийн хөдөлгөөний урсгалыг хадгалах, хурдасгах зорилгоор тухайн агаарын зайн ангилал болон нислэгийн төрлийн дагуу НХУ-ын зөвшөөрөл, зааварчилгаа болон мэдээллээр хангах;
- (3) бусад НХУ-ын нэгжтэй, шаардлагатай зөвшөөрлийг харилцан зохицуулах;
- (4) олгосон зөвшөөрлийн бүртгэлийн хамт, тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд боломжтой хэлбэрээр агаарын хөлгийн хөдөлгөөний мэдээллийг харуулах.

(b) Энэ зүйлийн (d) болон 172.91-д зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (a)(2)-т шаардсан журам нь энэ зүйлийн (c)-гийн дагуу босоо, эсхүл хэвтээ, эсхүл хосолмол зайчлалаар дараах нислэгүүдийг хангах үүрэгтэй болохыг заах ёстой:

- (1) “А” болон “В” ангиллын агаарын зайд үйлдэж байгаа бүх нислэг;
- (2) “С”, “D” болон “Е” ангиллын агаарын зайд үйлдэж байгаа IFR нислэг;
- (3) “С” ангиллын агаарын зайд үйлдэж байгаа IFR болон VFR нислэг;
- (4) “В”, “С”, “D” ангиллын агаарын зайд IFR болон тусгай VFR нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг;
- (5) “В”, “С,” болон “D” ангиллын агаарын зайд үйлдэж байгаа тусгай VFR нислэг, нислэгийн алсын барааны харагдац 5 км-ээс бага байхаар мэдээлсэн үед.

(c) Энэ зүйлийн (b)-д шаардсан зайчлал нь дараах баримт бичигт заасан холбогдох шалгуур болон минима-д нийцсэн байх ёстой:

- (1) E Бүлэг; эсхүл
- (2) Хавсралт 11; эсхүл
- (3) Дос 4444; эсхүл
- (4) Дос 7030.

(d) “D” ба “Е” ангиллын агаарын зайд, хэрэв нисгэгч IFR-аар үйлдэж байгаа бусад нислэгээс өөрийн зайчлал барихаар зөвшөөрөгдсөн бол энэ зүйлийн (b)(2)-т шаардсан НХУ-ын зайчлал тухайн IFR нислэгт хамаарахгүй. Дараахаас бусад тохиолдолд энэ зөвшөөрлийг олгохгүй:



- (1) тухайн зөвшөөрөл нь агаарын хөлгийн нисгэгчийн тусгайлан гаргасан хүсэлтийн дагуу байх;
- (2) тухайн нислэг өдрийн цагаар, VMC нөхцөлд байх;
- (3) НХУ-ний ажиглалтын удирдлагын үйлчилгээ байхгүй;
- (4) тухайн зөвшөөрлийг нислэгийн тодорхой үе шатанд зориулсан байх;
- (5) үндсэн нислэгийн хөдөлгөөн байж болох бүх нислэгийн нисгэгчид тухайн журмыг ашиглахыг зөвшөөрсөн байх;
- (6) үндсэн нислэгийн хөдөлгөөний мэдээллийг, нөлөөлөгдөх бүх нислэгийн нисгэгчид хүргүүлсэн байх;
- (7) тухайн нислэг нь НХУ-ын холбооны ижил давтамж дээр байх.

### **172.77. Аэродромын удирдлагын үйлчилгээ**

(а) Аэродромын удирдлагын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах тогтолцоо болон журмыг тогтоосон байна:

- (1) хүлээн авсан мэдээлэл болон ил харааны ажиглалтаар мэдэгдэж байгаа агаарын хөлөг хоорондын хамаарах байршлыг тогтоох;
- (2) дараах ойртолтоос сэргийлэх зорилгоор НХУ-ын зөвшөөрөл, зааварчилгаа болон мэдээллээр хангах:
  - (i) аэродромын ойролцоо нисэж байгаа агаарын хөлөг;
  - (ii) хөөрөлт болон буулт үйлдэж байгаа агаарын хөлөг;
  - (iii) маневрын талбайд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг;
  - (iv) маневрын талбайд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг, тээврийн хэрэгсэл болон хүн;
  - (v) маневрын талбайд байгаа агаарын хөлөг болон талбайд байгаа саад.
- (3) аюулгүй, үр дүнтэй нислэгийн хөдөлгөөний урсгалыг хадгалах болон хурдасгах зорилгоор НХУ-ын зөвшөөрөл, зааварчилгаа болон мэдээллээр хангах;
- (4) 172.91 болон 172.295-д зааснаас бусад тохиолдолд, дараах баримт бичигт заасан шалгуур болон минима-гийн дагуу ХБЗ-ны болон дагалдах хуйлралын зайчлалаар хангах:
  - (i) Хавсралт 11; эсхүл
  - (ii) Дос 4444; эсхүл
  - (iii) Дос 7030; эсхүл
  - (iv) Е Бүлэг.
- (5) агаарын хөлгийн онцгой нөхцөлийн үед ашигладаг тээврийн хэрэгсэл нь гадаргуу дээрх бусад бүх хөдөлгөөнөөс давуу эрхтэй болохыг бататгах;
- (6) гадаргуу дээрх хөдөлгөөнд, эсхүл агаарын хөлөг буух, явгалах, эсхүл хөөрөхөд учрах аюулаас зайлсхийхэд шаардлагатай, маневрын талбайд чирүүлж байгаа агаарын хөлгийг багтаасан хүн, эсхүл тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг удирдлагаар хангах;
- (7) бусад НХУ-ний нэгжтэй харилцан зохицуулалт хийх;
- (8) тухайн үйл ажиллагааны нэгжид агаарын хөлгийн хөдөлгөөний шинэчлэгдсэн мэдээллийг дэлгэцээр тасралтгүй үзүүлэх.

(b) Хүсэлт гаргагч нь, радио-холбоо ашиглах боломжгүй үед энэ зүйлийн (a)(2)-т шаардсан үндсэн зөвшөөрөл, зааварчилгаа болон мэдээллийг ИНД-91.243-т заасан гэрлэн дохио ашиглан дамжуулж чаддаг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

(c) Хүсэлт гаргагч нь цаг агаараар, эсхүл ойртолтын категориор, эсхүл хоёулангаар нь шаардсан тохиолдолд дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) ILS, эсхүл MLS ойртолт үйлдэж байгаа агаарын хөлөгт ILS/MLS-ийн эрсдэлтэй бүсэд нэвтэрсэн, эсхүл нэвтрэх аюултай болсныг мэдээлдэг байх; эсхүл
- (2) агаарын хөлөг ILS, эсхүл MLS ойртолт үйлдэж байхад, эсхүл нэвтрэхээс хамгаалах шаардлагатай, тухайн ойртолтын цэгт хүрсэн үед холбогдох ILS/MLS-ийн эрсдэлтэй бүс нь нэвтрэхээс хамгаалагдсан байх.

(d) Хүсэлт гаргагч нь 172.91-д заасан ба холбогдох ойртолтын удирдлагын үйлчилгээний нэгжээс зөвшөөрөл авах шаардлагатай байхаас бусад тохиолдолд, аэродромын удирдлагын үйлчилгээний нэгж дараах нислэгүүдийн хооронд зайчлалаар хангадаг болохыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) IFR нислэг болон тусгай VFR нислэг;
- (2) тусгай VFR нислэг, нислэгийн алсын барааны харагдац 5 км-ээс бага байхаар мэдээлсэн үед.

(e) Хүсэлт гаргагч нь эрх шилжүүлсэн болон хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, холбогдох бүс, эсхүл ойртолтын удирдлагын үйлчилгээний нэгж, аэродромын удирдлагын үйлчилгээний нэгж нь тухайн шилжүүлсэн эрхийн дагуу хяналттай нислэгийг хоорондын зайчлалаар хангадаг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

(f) Энэ зүйлийн (d) болон (e)-д шаардсан зайчлалыг дараах баримт бичигт заасан шалгуур болон минима-гийн дагуу босоо, эсхүл хэвтээ, эсхүл хосолмол зайчлал ашиглан тогтооно:

- (1) Хавсралт 11; эсхүл
- (2) Doc 4444; эсхүл
- (3) Doc 7030; эсхүл
- (4) E Бүлэг.

### **172.79. Тусгай зориулалтаар ашиглах агаарын зай**

НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараахаас бусад тохиолдолд, ИНД-71-ийн дагуу тогтоосон тусгай зориулалтаар ашиглах идэвхтэй байгаа агаарын зайд болон хяналттай нислэгүүдийн хооронд 172.293-ын дагуу зайчлалаар хангасан болохыг бататгах систем болон журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) нисгэгч тухайн агаарын зайг хариуцсан эрх бүхий байгууллагаас тухайн агаарын зайд үйл ажиллагаа гүйцэтгэх зөвшөөрөл авсан байх; эсхүл
- (2) аюултай бүс, эсхүл галт уулын аюултай зооны хувьд, тухайн нисгэгч нь аюултай бүс, эсхүл галт уулын аюултай зоонд үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоо мэдэгдсэн байх; эсхүл

- (3) VFR нислэг, эсхүл IFR нислэгийг ил харааны баримжаа ашиглан гүйцэтгэж байгаа нисгэгч тухайн агаарын зай идэвхтэй болохыг мэдэж байгааг, хүсэлт гаргагч мэдэж байгаа, эсхүл мэдэж байгаа гэдэгт итгэх шалтгаан байгаа; эсхүл
- (4) нисгэгчийн хүсэлтээр, тухайн нислэг нь тухайн агаарын зайнаас өөрийн зайчлалыг хадгалахаар зөвшөөрөгдсөн.

### **172.81. Хяналтын хариуцлага**

- (a) НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч, аливаа хяналттай нислэг нь аль ч цаг хугацаанд зөвхөн нэг НХУ-ын үйл ажиллагааны нэгжийн удирдлагад байдаг болохыг бататгах журмыг тогтоосон байна.
- (b) Хүсэлт гаргагч нь, агаарын зайн өгөгдсөн хэсэгт үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бүх агаарын хөлгийг хянах хариуцлагыг зөвхөн нэг үйл ажиллагааны нэгж хариуцдаг болохыг бататгах журмыг тогтоосон байна. Агаарын хөлөг, эсхүл бүлэг агаарын хөлгүүдийн хяналтыг, нөлөөлөгдөх бүх үйл ажиллагааны нэгж хоорондын зохицуулалтыг баталгаажуулан хангасан тохиолдолд, бусад үйл ажиллагааны нэгжид шилжүүлдэг байж болно.
- (c) Хүсэлт гаргагч нь агаарын хөлгийн хяналтын хариуцлагыг шилжүүлэх журмыг тогтоосон байна.
- (d) Энэ зүйлийн (c)-д заасан журам нь дараах шаардлага хангасан болохыг бататгана:
  - (1) хяналтыг шилжүүлэх зохицуулалтыг:
    - (i) зэргэлдээх агаарын зайг хариуцдаг НХУ-ын нэгжүүд хоорондоо зөвшилцсөн байх ба НХУ-ний гэрээнд зааж, хэвлэн нийтэлсэн байх;
    - (ii) тухайн НХУ-ын нэгжийн хүрээнд, тусдаа бие даасан үйл ажиллагааны нэгжид хийсэн байх ба эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт заасан байх;
  - (2) дараах нөхцөлийг хангахгүйгээр, агаарын хөлгийн удирдлагын хариуцлагыг НХУ-ын нэг нэгжээс бусдад шилжүүлдэггүй байх:
    - (i) хүчинтэй нислэгийн төлөвлөгөөний шаардлагатай хэсгийг мэдэгдэх;
    - (ii) удирдлагатай холбоотой аливаа мэдээлэлтэй байх;
    - (iii) тухайн үйлчилгээг хүлээн авсан нэгж зөвшөөрсөн байх.

### **172.83. Давуу эрх**

- (a) НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХУ-ын нэгж аюулгүй байдлыг алдагдуулахгүй байх нөхцөлийг ханган, дараах давуу эрхийг олгодог болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:
  - (1) онцгой нөхцөл, эсхүл үйл ажиллагааны доголдолтой байдалд орсон нь мэдэгдэж байгаа, эсхүл орсон гэдэгт итгэж байгаа агаарын хөлөг бусад агаарын хөлгөөс давуу эрхтэй байх;
  - (2) буулт үйлдэж байгаа, эсхүл буулт үйлдэхээр ойртолтын төгсгөлийн үе шатанд байгаа агаарын хөлөг нисэн гарч байгаа агаарын хөлгөөс давуу эрхтэй байх;
  - (3) буулт үйлдэж байгаа, эсхүл хөөрөлт үйлдэж байгаа агаарын хөлөг явгалж байгаа агаарын хөлгөөс давуу эрхтэй байх.

(b) Хүсэлт гаргагч нь боломжтой тохиолдолд, нисгэгчийн гаргасан хүсэлтийн дагуу дараах ажиллагаанд оролцож байгаа, эсхүл оролцохоор байрласан агаарын хөлөгт давуу эрх олгодог болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) түргэн тусламжийн, эсхүл хүмүүнлэгийн тусламжийн нислэг;
- (2) эрэн хайх, авран туслах нислэг;
- (3) иргэний хамгаалалтын, эсхүл цагдаагийн онцгой нөхцөлийн нислэг;
- (4) төр засгийн тэргүүн, эсхүл түүнтэй дүйцэх этгээдийн нислэг.

(c) Хүсэлт гаргагч нь, ихэнх тохиолдолд аяллын түвшинд байгаа агаарын хөлгийг тухайн түвшинд гарах хүсэлт гаргасан бусад агаарын хөлгөөс давуу эрхтэй болохыг бататгах журмыг дараах шаардлагын дагуу тогтоосон байх үүрэгтэй:

- (1) Doc 7030, эсхүл НХУ-ний гэрээнд заасан журмын дагуу агаарын хөлөгт аяллын түвшний давуу эрхийг олгох;
- (2) аяллын түвшнийг хадгалж байгаа агаарын хөлөгт зайчлалыг хадгалах зорилгоор өөр түвшнийг дахин тогтоох.

(d) Бүсийн удирдлагын үйлчилгээ эрхлэх зорилгоор НХУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-71-ийн дагуу RNP тогтоосон агаарын зайд олгох давуу эрхийн журмыг тогтоосон байна.

(e) Энэ зүйлийн (a) болон (b)-гийн шаардлагыг харгалзан, хүсэлт гаргагч нь тухайн схемийг хэрэгжүүлэхийн өмнө сонирхогч талуудтай зөвшилцсөн тохиолдолд, нисэн ирэх болон нисэн гарах нислэгийн давуу эрхийг тогтоох хуваарийг гаргаж болно.

(f) Хүсэлт гаргагч нь, хэрэв давуу эрхийг энэ зүйлийн (d) болон (e)-гийн дагуу тогтоосон бол, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан холбогдох мэдээллийг Монгол Улсын AIP-д хэвлэн нийтэлдэг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(g) Хүсэлт гаргагч нь дараах үйл ажиллагаанд аэродромын үйл ажиллагаа эрхлэгчтэй хамтран тогтоосон давуу эрхийг тооцон үзэж, аюулгүй байдал алдагдахгүйгээр үйлчилгээгээр хангадаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) тухайн аэродромд нисэн ирж байгаа болон нисэн гарч байгаа агаарын хөлөг;
- (2) тухайн аэродромтой холбоотой удирдлагын зооны бусад үйл ажиллагаа.

(h) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн бусад шаардлагын дагуу давуу эрх олгосноос бусад тохиолдолд, нисэн ирэх болон нисэн гарах нислэгийн хувьд, түрүүлж ирсэн нь түрүүлж үйлчлүүлэх зарчмаар давуу эрх эдэлдэг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

(i) Хүсэлт гаргагч нь НХУ-ын үйлчилгээний хангалтыг дараах үйл ажиллагаанаас давуу ач холбогдолтой болохыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) нөхцөл байдал шаардсан аль ч үед, нислэгийн мэдээллийн үйлчилгээ;
- (2) НХУ-ний бус аливаа бусад ажил гүйцэтгэх.

**172.85. Хөдөлгөөний урсгал зохицуулалт**

(a) НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХУ-ний системийн хүчин чадал, эсхүл аэродромын хүчин чадлын хязгаарлалтаас шалтгаалан, хүсэлт гаргагч шаардлагатай гэж үзвэл нислэгийн хөдөлгөөний урсгалын зохицуулалтын журмыг тогтоосон байна.

(b) Тухайн журамд дараах шаардлагыг тооцож үзсэн байна:

- (1) тэдний хөдөлгөөнийг зохицуулах давуу эрхийг багтаасан, нөлөөлөгдөх аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлага;
- (2) тухайн журам нөлөөлөх агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон бусад НХУ-ний нэгжийн хэрэгцээ;
- (3) идэвхжүүлэлт болон идэвхгүйжүүлэлтийн аргачлалын талаар урьдчилсан мэдэгдэл болон мэдээллийг багтаасан, нисэхийн мэдээллийн үйлчилгээний шаардлага.

**172.87. НХУ-ын зөвшөөрөл**

(a) НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХУ-ын зөвшөөрөл олгох журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах шаардлагыг бататгасан байна:

- (1) этгээд нь мэдсээр байж, аливаа бусад зүйл, заалтын шаардлагыг зөрчихийг нисгэгчээс шаардсан, эсхүл хүссэн НХУ-ын зөвшөөрөл, эсхүл зааварчилгааг өгдөггүй байх;
- (2) зөвшөөрөл болон зааварчилгаа нь зөвшөөрсөн эерэг болон товч өгөгдлийг агуулдаг байх ба боломжтой бүх тохиолдолд, стандарт хэлбэрээр илэрхийлэгддэг байх;
- (3) хэрэв нисгэгч тухайн зөвшөөрөл, эсхүл зааварчилгаа нь тохиромжгүй болохыг мэдэгдсэн бол, боломжтой тохиолдолд өөрчилсөн зөвшөөрөл, эсхүл зааварчилгааг олгодог байх;
- (4) нислэгийн замын дагуух НХУ-ын зөвшөөрөл нь дараах мэдээллээс бүрддэг байх:
  - (i) нислэгийн төлөвлөгөөнд заасан агаарын хөлгийн таних тэмдэг, эсхүл өөр нислэгтэй ижил төстэй байдал нь төөрөгдөлд хүргэх шалтгаан болох тохиолдолд НХУ-ын олгосон өөр орлох таних тэмдэг;
  - (ii) тухайн зөвшөөрлийн хязгаар;
  - (iii) нислэгийн чиглэл;
  - (iv) нислэгийн бүх замын, эсхүл түүний хэсгийн нислэгийн түвшин, хэрэв шаардлагатай бол түвшний өөрчлөлт;
  - (v) ойртолтын, эсхүл нисэн гарах маневр, холбоо болон тухайн зөвшөөрлийн хүчинтэй байх, эсхүл дуусах цаг зэрэг бусад асуудалтай холбоотой, шаардлагатай зааварчилгаа, эсхүл мэдээлэл;
- (5) орон нутгийн нислэгийн НХУ-ний зөвшөөрлийн хувьд, тогтоосон бүсэд гүйцэтгэх нислэгийн үйл ажиллагаа, эсхүл төлөвлөгдөөгүй нислэгийн үйл ажиллагаанд энэ хэсгийн (4)-т дэлгэрэнгүй заасан тохирох нөхцөлийг багтаадаг байх;

- (б) дууны хурдны ойролцоо хурдтай нислэгийн хувьд НХУ-ын зөвшөөрөл нь:
- (i) дууны хурдны ойролцоо хурд авах үе шатны төгсгөл хүртэл үргэлжилдэг байх;
  - (ii) дуунаас хэт хурдан аяллын нислэгээс дууны хурдны өмнөх хурдтай нислэгт шилжих хүртэл тасалдалгүй үргэлжүүлэн өндөр алдах нөхцөлөөр хангадаг байх.

### **172.89. Аяллын түвшин**

(а) НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хяналттай агаарын зайд байхаас бусад тохиолдолд, Монгол Улсын FIR-д тогтоосон аяллын түвшнийг IFR нислэгт ИНД-91.425-ын дагуу, эсхүл VFR нислэгт ИНД-91.313-ын дагуу дараах нислэгт ашигладаг болохыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) аяллын түвшнийг нислэгийн чиглэлтэй хамаатуулан холбох шаардлагагүй, IFR болон VFR нислэг хоёуланд нь;
- (2) IFR түвшнийг олгож болох VFR нислэг.

### **172.91. НХУ-ын зөвшөөрлөөс хазайх**

(а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НХУ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХУ-аас өгөх, алдсан зайчлалыг сэргээх зааварчилгаа нь дараах нөхцөлд нисгэгчийн үйлдэлд саад болдоггүй болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) ACAS-ын resolution advisory; эсхүл
- (2) GPWS, эсхүл TAWS-ын анхааруулах дохио; эсхүл
- (3) НХУ-ын зөвшөөрлөөс хазайхыг шаардсан цаг агаар, эсхүл бусад онцгой нөхцөл байдал.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журамд, хэрэв зайчлал алдсан бол түүнийг тухайн онцгой нөхцөл байдлыг шийдвэрлэсний дараа сэргээдэг болохыг заасан байх ёстой.

### **172.93. Нислэгийн мэдээллийн үйлчилгээ**

#### **Ерөнхий зүйл**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, дараах агаарын хөлөгт нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (b)-д заасан мэдээлэл нөлөөлж болзошгүй, НХУ-ын үйлчилгээгээр хангагдаж байгаа агаарын хөлөг бүрд;
- (2) энэ зүйлийн (b)-д заасан мэдээлэл нөлөөлж болзошгүй, аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээгээр хангагдаж байгаа агаарын хөлөг бүрд;
- (3) энэ зүйлийн (b)-д заасан мэдээлэл нөлөөлж болзошгүй, IFR нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг бүрд;
- (4) нисгэгч НХУ-ний нэгжид VFR нислэгийн төлөвлөгөө хүргүүлсэн, VFR нислэг үйлдэж байгаа аливаа агаарын хөлөгт;
- (5) хэрэв нисгэгч НХУ-ний нэгжид нислэгийн мэдээлэл авах тусгай хүсэлт гаргасан бол, VFR нислэг үйлдэж байгаа аливаа агаарын хөлөгт.

(b) Хүсэлт гаргагч нь нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор энэ зүйлийн (a)-д шаардсан журамд, хэрэглэхэд бэлэн байгаа болон дараах холбогдох мэдээлэл багтсан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) SIGMET мэдээлэл;
- (2) нисэн гарах, буулт үйлдэх болон бэлтгэл аэродромын мэдээлэгдсэн цаг агаарын нөхцөлийн, эсхүл урьдчилсан мэдээний мэдээлэл;
- (3) дэлбэрэхийн өмнөх галт уулын идэвхжил, галт уулын дэлбэрэлт, галт уулын үнсэн үүлний мэдээлэл;
- (4) атмосферт цацраг идэвхт материал, эсхүл хорт бодис цацагдсан мэдээлэл;
- (5) навигацийн туслах төхөөрөмжийн ажиллагаатай байдлын өөрчлөлтийн мэдээлэл;
- (6) цас, мөс, эсхүл ус нөлөөлсөн бол, аэродромын хөдөлгөөнт талбайн нөхцөл байдлыг багтаасан, аэродром болон холбогдох байгууламжийн нөхцөлийн өөрчлөлтийн мэдээ;
- (7) хүнгүй чөлөөт бөмбөлгийн мэдээлэл;
- (8) аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй бусад мэдээлэл.

(c) Аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ХБЗ дээр ус байгаа тохиолдолд, ХБЗ-ны өргөний төвийн хагасын ХБЗ-ны гадаргуугийн нөхцөлийг дараах аль нэг нэр томъёог ашиглан тодорхойлдог болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) DAMP - тухайн гадаргуу нь чийгээс шалтгаалсан өнгөний өөрчлөлттэй байх;
- (2) WET - тухайн гадаргуу нь норсон боловч тогтоол усгүй байх;
- (3) WATER PATCHES - ихэнх хэсэг нь тогтоол устай байх;
- (4) FLOODED - их хэмжээний тогтоол ус байх.

(d) Аэродромын удирдлагын үйлчилгээ, ойртолтын удирдлагын үйлчилгээ, эсхүл, аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхээр НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь хэрэв боломжтой бол, тухайн үйлчилгээ үзүүлэх хэвлэн нийтэлсэн цагийн гэнэтийн өөрчлөлтийг үйл ажиллагаанд нь нөлөөлж болох орон нутгийн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид, (хэрэв тэд бусад эх үүсвэрээс мэдээлэл авах боломжгүй бол) мэдээлдэг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

### **Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл**

(e) НХҮ-ын үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь үндсэн нислэгийн хөдөлгөөний мэдээллийг нөлөөлөгдсөн бүх нислэгийн хөдөлгөөнд оролцогчдод мэдээлдэг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(f) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн гэрчилгээний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа НХҮ-ний нэгж бүр, тухайн нэгжид мэдэгдэж байгаа ба тухайн мэдээлэл дараах байдлаар нөлөөлж болзошгүй нислэгт нислэгийн хөдөлгөөний мэдээллээр хангадаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) “С” ангиллын агаарын зайд, нисгэгчийн хүсэлтээр VFR нислэг хооронд нислэгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зөвлөмжийн хамт;

- (2) “D” ангиллын агаарын зайд, IFR болон VFR нислэг хооронд ба нисгэгчийн хүсэлтээр, VFR нислэг хооронд нислэгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зөвлөмжийн хамт;
- (3) хэрэв боломжтой бол, “E” ангиллын агаарын зайд, нисгэгчийн хүсэлтээр IFR болон VFR нислэгийн хооронд;
- (4) “G” ангиллын агаарын зайд, IFR нислэг хооронд, хэрэв боломжтой бол, нисгэгчийн хүсэлтээр бусад нислэг хооронд.

### 172.95. Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ

(a) Аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах тогтолцоо болон журмыг тогтоосон байна:

- (1) хүлээн авсан мэдээлэл болон ил харааны ажиглалтаар мэдэгдэж байгаа агаарын хөлөг хоорондын хамаарах байршлыг тогтоох;
- (2) дараах агаарын хөлгийн аюулгүй болон үр дүнтэй нислэгийн үйл ажиллагааны зорилгод нийцсэн ХБЗ-ны сонголтыг багтаасан зөвлөмж болон мэдээллээр хангах:
  - (i) аэродромын ойролцоо нисэж байгаа агаарын хөлөг;
  - (ii) маневрын талбайд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг;
  - (iii) хөөрөлт болон буулт үйлдэж байгаа агаарын хөлөг;
  - (iv) маневрын талбайд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөг, тээврийн хэрэгсэл болон хүн;
  - (v) маневрын талбайд байгаа агаарын хөлөг болон талбайд байгаа саад.

(b) Хүсэлт гаргагч нь сонгосон, нийцэх ХБЗ нь тухайн үйл ажиллагаанд хамгийн тохиромжтой болохыг бататгах журмыг тогтоосон байна.

### 172.97. Анхааруулах үйлчилгээ

(a) Энэ Дүрэмд:

**ALERFA** - Анхааруулах үе шат;

**DETRESFA** - Аюул тулгарсан үе шат;

**INSERFA** - Тодорхойгүй үе шат;

**SARCC** - энэ Дүрмийн дагуу ИНЕГ-ын байгуулсан ЭХАТ зохицуулалтын төв.

(b) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, өөрийн хариуцлагын бүсэд дараах анхааруулах үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг бататгах тогтолцоо болон журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) аэродромын бүх нислэгийн хөдөлгөөний хувьд, аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээгээр хангаж байгаа тохиолдолд;
- (2) бүх агаарын хөлгийн хувьд:
  - (i) ИНД-91.307, эсхүл 91.407-гийн дагуу хүргүүлсэн нислэгийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа; эсхүл
  - (ii) тусламж шаардлагатай болохыг НХҮ бусад хэлбэрээр мэдсэн; эсхүл
  - (iii) хууль бус үйлдэлд өртсөн нь мэдэгдэж байгаа, эсхүл өртсөн гэдэгт итгэж байгаа.



(с) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (f)-д заасан онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд, дараах арга хэмжээг авдаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (f)-ийн дагуу INCERFA, ALERFA, эсхүл DETRESFA яаралтай мэдэгдэх;
- (2) орон нутгийн онцгой байдлын албатай хамтран тухайн онцгой нөхцөлийг зохицуулж чаддаг байхаас бусад тохиолдолд, хариуцсан бүсийн удирдлагын төв, эсхүл нислэгийн мэдээллийн төвд мэдэгддэг байх.

(d) Бүсийн удирдлагын үйлчилгээ, эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд, тухайн бүсийн удирдлагын төв, эсхүл нислэгийн мэдээллийн төв дараах үйлчилгээ үзүүлдэг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) онцгой нөхцөл байдалтай холбоотой мэдээллийг цуглуулахад, тухайн FIR-ийн хүрээнд үндсэн төв хэлбэрээр үйлчлэх;
- (2) энэ зүйлийн (l)(1)-д зааснаас бусад тохиолдолд, цуглуулсан мэдээллийг ЭХАТ зохицуулалтын төвд яаралтай дамжуулах.

(e) Энэ зүйлийн (с)-г үл харгалзан, аэродромын удирдлагын үйлчилгээ, ойртолтын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, тухайн нөхцөлд яаралтай арга хэмжээ авахыг шаардаж байгаа тохиолдолд, эдгээр арга хэмжээний талаар холбогдох орон нутгийн онцгой байдлын албанд анхны анхааруулга өгдөг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(f) Энэ зүйлийн (с)-д шаардсан мэдэгдлийг дараах нөхцөлд болон тухайн мэдэгдлийг гаргах шаардлагатай бусад нөхцөлд гаргадаг байх ёстой:

- (1) INSERFA / Тодорхойгүй үе шат - тухайн агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд эргэлзээ байхгүй байхаас бусад, дараах тохиолдолд:
  - (i) IFR, эсхүл хяналттай VFR нислэг үйлдэж байгаа агаарын хөлгөөс холбоогоор хариу хүлээж авсан байх ёстой хугацаанаас хойш, эсхүл тухайн агаарын хөлөгтэй холбоо тогтоох анхны амжилтгүй оролдлого хийсэн хугацаанаас хойш 15 минутын дотор холбоогоор хариу хүлээж аваагүй байхын аль түрүүлж болох; эсхүл
  - (ii) нисгэгч нислэгийн төлөвлөгөөгөө цуцалж, эсхүл тогтоосон SARTIME-д өөрчлөлт оруулж чадаагүй ба тухайн агаарын хөлгийн байрлалыг тогтоох яаралтай оролдлого бүтэлгүйтсэн; эсхүл
  - (iii) SARTIME өгөөгүй, VFR нислэгийн төлөвлөгөөний дагуу VFR нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг нисэн ирэх тооцоот цагаас хойш 30 минутын дотор нисэн ирээгүй; эсхүл
- (2) ALERFA / Анхааруулах үе шат - энэ зүйлийн (ii), (iii) болон (iv)-ийн хувьд, агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд эргэлзэх нотолгоо байгаагаас бусад, дараах тохиолдолд:
  - (i) агаарын хөлөг хууль бус үйлдэлд өртсөн нь мэдэгдэж байгаа, эсхүл өртсөн гэдэгт итгэж байгаа; эсхүл

- (ii) тодорхойгүй үе шатны дараа тухайн агаарын хөлөгтэй холбоо тогтоох дараалсан оролдлого, эсхүл бусад холбогдох эх үүсвэрээс авсан лавлагаагаар тухайн агаарын хөлгийн талаар шинэ мэдээ олж авч чадаагүй; эсхүл
  - (iii) агаарын хөлөг буулт үйлдэх зөвшөөрөл авсан ба буулт үйлдэх тооцоот цагаас хойш 5 минутын дотор буулт үйлдэж чадаагүй бөгөөд тухайн агаарын хөлөгтэй холбоог дахин тогтоож чадаагүй; эсхүл
  - (iv) тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааны хүчин чадал доголдсон хэдий ч аргагүйдсэн буулт үйлдэж болзошгүй нөхцөлд хүрээгүй тухай мэдээлэл хүлээж авсан; эсхүл
- (3) *DETRESFA* / Аюул тулгарсан үе шат - агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүст ноцтой, үхлийн аюул тулгараагүй ба тухайн тулгарсан аюул нь яаралтай тусламж шаардаагүй гэдэгт итгэлтэй байхаас бусад, дараах тохиолдолд:
- (i) анхааруулах үе шатны дараа, тухайн агаарын хөлөгтэй холбоо тогтоох үргэлжилсэн амжилтгүй оролдлого болон өргөн хэмжээний амжилтгүй лавлагаа нь тухайн агаарын хөлөг аюулд өртсөн байж болох магадлалыг зааж байгаа; эсхүл
  - (ii) тухайн агаарын хөлөгт байгаа түлш дууссан, эсхүл тухайн агаарын хөлгийг аюулгүй буулт үйлдэхэд хангалттай биш гэж үзсэн; эсхүл
  - (iii) тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааны хүчин чадал доголдсон ба аргагүйдсэн буулт үйлдэж болзошгүй болохыг харуулж байгаа мэдээлэл хүлээж авсан; эсхүл
  - (iv) тухайн агаарын хөлөг аргагүйдсэн буулт үйлдэх гэж байгаа, эсхүл үйлдсэн гэж үзэх мэдээлэл хүлээж авсан, эсхүл үүнд итгэх тодорхой шалтгаан байгаа.
- (g) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (c)(2)-т шаардсан онцгой нөхцөл байдлын мэдэгдэлд дараах мэдээллийг бэлэн байгаа байдлаар, жагсаалтын дарааллаар багтаасан болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:
- (1) *INCERFA*, *ALERFA*, эсхүл *DETRESFA*-гийн аль тохирох онцгой нөхцөлийн үе шат;
  - (2) харилцаж байгаа эрх бүхий байгууллага болон этгээдийн нэр;
  - (3) онцгой нөхцөлийн шинж чанар;
  - (4) нислэгийн төлөвлөгөөний онцгой чухал мэдээлэл;
  - (5) сүүлд холбоо барьсан үйлчилгээний нэгж, цаг болон ашигласан давтамж;
  - (6) сүүлчийн байршлын мэдээлэл болон хэрхэн тогтоосон арга;
  - (7) агаарын хөлгийн өнгө болон онцгойлсон ялгах тэмдэг;
  - (8) мэдээлж байгаа салбарын авсан арга хэмжээ.
- (h) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь онцгой нөхцөл байдлын талаар мэдээлэл хийсний дараа ЭХАТ зохицуулалтын төвийг дараах мэдээллээр шуурхай хангадаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:
- (1) ашиглахад шаардлагатай нэмэлт мэдээлэл;
  - (2) тухайн онцгой нөхцөл байдлыг шийдвэрлэсэн тухай мэдэгдэл.

(i) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь онцгой нөхцөл байдалд орсон агаарын хөлөгтэй холбоо тогтоох, холбоог хадгалах болон тухайн агаарын хөлгийг байнга хянахад шаардлагатай боломжит бүх хэрэгслийг ашигладаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(j) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь онцгой нөхцөл байдал бий болсон гэж үзвэл, онцгой нөхцөлд орсон агаарын хөлгийн мэдэгдэж байгаа сүүлчийн байршлыг тогтоож, бүртгэдэг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(k) *хамааралгүй*

(l) Бүсийн удирдлагын үйлчилгээ, эсхүл нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) бүсийн удирдлагын төв, эсхүл нислэгийн мэдээллийн төв нь INCERFA, эсхүл ALERFA зарласан бол, боломжтой тохиолдолд ЭХАТ зохицуулалтын төвд мэдээлэхээс өмнө тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгддэг байх;
- (2) ЭХАТ зохицуулалтын төвд мэдээлсэн бүх мэдээллээр, боломжтой тохиолдолд, тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг нэн даруй хангадаг байх.

#### **172.99. Нислэгийн төлөвлөгөө**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах болон хэрэгжүүлэх журмыг тогтоосон байна.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-д шаардсан хүлээн авах журамд, хүргүүлсэн нислэгийн төлөвлөгөөг анх хүлээн авч байгаа НХҮ-ний нэгж нь дараах үйл ажиллагаа багтдаг болохыг бататгасан байна:

- (1) тогтоосон нислэгийн төлөвлөгөөний формат болон өгөгдлийн нөхцөлт тэмдэглэгээний нийцлийг шалгах;
- (2) бүрэн гүйцэд бөглөсөн байдал болон боломжтой хэлбэрээр нарийвчлалыг шалгах;
- (3) тухайн нислэгийн төлөвлөгөөг НХҮБ хүлээн авахад шаардагдах аливаа бусад ажиллагаагаар хангах.

(c) Нэгээс дээш байршлаас НХҮ үзүүлэхээр төлөвлөж байгаа хүсэлт гаргагч нь, бусад үйлчилгээний нэгжийн өмнөөс хүргүүлсэн нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах зорилгоор тухайн хүсэлт гаргагчийн байгууллагад НХҮ-ний нэг нэгжийг томилж болно.

(d) Төвлөрсөн нислэгийн төлөвлөлтийн нэгж ажиллуулахаар төлөвлөж байгаа НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн нэгжийг дараах төхөөрөмжөөр тоногдсон болохыг бататгана:

- (1) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн болон бусад НХҮ-ний нэгжийн нислэгийн төлөвлөгөөг хүлээн авах зорилгоор AFS, факс болон компьютерын өгөгдлийн сүлжээний байгууламж;
- (2) стандарт болон нислэгийн төлөвлөгөөний мэдээллийн давтагдах элементийг урьдчилан хүргүүлэх, хадгалах болон хэрэгжүүлэх байгууламж.

**172.101. Цаг**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь, НХҮ-ний нэгжийн цаг болон бусад цаг бүртгэх төхөөрөмж дараах шаардлага хангадаг болохыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) UTC 00:00-д өдөр эхэлдэг, 24 цагийн цаг болон минутаар илэрхийлэгддэг Олон Улсын Цагийг (UTC) хэрэглэдэг байх;
- (2) стандарт цагийн төхөөрөмж, эсхүл GPS цагийн стандартаар харьцуулан тодорхойлсон, UTC цагийг 5 секундийн нарийвчлалтайгаар зөв заадаг байх.

(b) Хүсэлт гаргагч нь дараах тохиолдолд, зөв цагийг хамгийн ойрын бүхэл минутад шилжүүлэн өгдөг болохыг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) аэродромын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээний хувьд, тухайн нисгэгч цагийг бусад эх үүсвэрээс авах зохицуулалт хийгдсэн байхаас бусад тохиолдолд, хөөрөлт үйлдэхээр явгалахын өмнө IFR нислэгийн агаарын хөлөгт;
- (2) хүсэлт гаргасан агаарын хөлөгт.

**172.103. Алтиметрийн тохируулга хийх журам**

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) QNH алтиметрийн тохируулгыг гектопаскаль нэгжээр хамгийн ойрын бүхэл утгаар илэрхийлдэг байх;
- (2) бодит ATIS мэдээг хүлээн авсан агаарын хөлгийг багтаан, тухайн агаарын хөлөг уг мэдээллийг хүлээн авсан болохыг мэдэж байхаас бусад тохиолдолд, аэродромын QNH алтиметрийн тохируулга, эсхүл бүсийн QNH зооны алтиметрийн тохируулгыг бүх агаарын хөлөгт анхны радио-холбоо тогтоох үед мэдээлдэг байх;
- (3) НХҮ-ний нэгж нь агаарын хөлгийн хүсэлтээр, аэродромын QNH алтиметрийн тохируулга, эсхүл бүсийн QNH зооны алтиметрийн тохируулгыг мэдээлдэг байх.

**172.105. Радио болон утсан холбооны журам**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах тогтолцоо болон журмыг тогтоосон байна:

- (1) энэ зүйлийн (b)-д заасан, утсан болон радио-холбооны стандарт хэвшмэл хэллэгийг ашигладаг байх;
- (2) зөвхөн НХҮ-ээр хангахад, эсхүл нислэгийн аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх шаардлагатай мэдээ дамжуулснаар, бүх радио-холбооны сахилга батыг сахидаг байх;
- (3) дараахаас бусад тохиолдолд, холбооны журам нь Annex 10 Volume II-т заасан холбооны журмын дагуу байх:
  - (i) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн орон нутагт ашигладаг дуудлагатай холбоотой журам нь ИНД-91.249-д шаардсаны дагуу байх;
  - (ii) аэродромын НМҮ нь радио-холбооны дуудлагын “Нислэгийн үйлчилгээ”-ний товчлолыг хэрэглэдэг байх.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-ийн зорилгоор, стандарт хэвшмэл хэллэг болон түүнийг ашиглах нөхцөл нь дараах хэвлэн нийтэлсэн баримт бичигтэй нийцэж байгааг бататгах журмыг тогтоосон байна:

- (1) F Бүлэг; эсхүл
- (2) Хавсралт 10; эсхүл
- (3) Дос 4444; эсхүл
- (4) Дос 9432.

(c) Энэ зүйлийн (b)-д заасан баримт бичиг өөр хоорондоо зөрүүтэй байгаа тохиолдолд, хэвшмэл хэллэгийг тухайн баримт бичгийн ач холбогдлын дарааллын дагуу сонгоно.

### **172.107. НХҮ-ний ажиглалтын үйлчилгээ**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ-ний ажиглалтын системийг НХҮ-ний хангалтыг дэмжихэд ашигладаг бол, дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) бүх НХҮ-ний ажиглалтын үйлчилгээг дараах баримт бичигт хэвлэн нийтэлсэн журмын дагуу үзүүлдэг байх:
  - (i) Дос 4444; эсхүл
  - (ii) Дос 7030 (Ойрх Дорнод/Азийн бүсэд хэрэглэх байдлаар нь); эсхүл
  - (iii) G Бүлэг;
- (2) олон улсын нислэгт SSR кодыг холбогдох ICAO Air Navigation Plan-д хэвлэн нийтэлсэн код тогтоох тогтолцооны дагуу олгодог байх;
- (3) орон нутгийн нислэгт SSR кодыг зохицуулах төлөвлөгөөг дараах шаардлагыг ханган, тогтоосон байх:
  - (i) Дос 4444-т заасан холбогдох зарчим;
  - (ii) ИНД-91.247(a)-ийн SSR код олгох хүснэгттэй зөрчилдөхгүй байх;
- (4) дараах бүрэн мэдээлэл нь нисгэгч болон агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч ашиглахад бэлэн байх:
  - (i) үзүүлж байгаа НХҮ-ний ажиглалтын үйлчилгээний мөн чанар, цар хүрээ;
  - (ii) тухайн НХҮ-ний ажиглалтын үйлчилгээний томоохон хязгаарлалт;
- (5) тухайн үзүүлдэг НХҮ-нд шаардлагатай мэдээллийг НХҮ-ний ажиглалтын үйлчилгээний үйл ажиллагааны нэгжид байрлуулсан байх.

### **172.109. Агаарын хөлгийн онцгой нөхцөлийн болон хэвийн бус үйл ажиллагаа**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь онцгой нөхцөл байдалд орсныг мэдэж байгаа, эсхүл орсон гэдэгт итгэж байгаа агаарын хөлөгт дээд зэргийн дэмжлэг болон давуу байдлыг олгодог болохыг бататгах журмыг тогтоосон байна.

(b) Хүсэлт гаргагч нь шаардлагатай тохиолдолд төөрсөн, үл танигдах болон цэргийн хүчээр албадан саатуулагдсан агаарын хөлөгт тусламж үзүүлэх журмыг тогтоосон байна.

**172.111. Ноцтой зөрчил, эсхүл ослын дараах арга хэмжээ**

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ноцтой зөрчил, эсхүл ослын талаар дараах журмыг тогтоосон байна:

- (1) хэрэв аливаа навигацийн байгууламж нь тухайн хэрэг явдал болоход нөлөөлсөн бол, түүнийг тогтоох;
- (2) дараах яаралтай арга хэмжээг авахыг бататгах:
  - (i) тухайн байгууламжийг ашиглаж байгаа, эсхүл ашиглахаар төлөвлөж байгаа бусад агаарын хөлөгт анхааруулах;
  - (ii) тухайн хэрэг явдалд нөлөөлсөн байгууламж болон оролцсон байж болох байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэх.
- (3) байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгчид тухайн төхөөрөмжийг үйлчилгээнээс хураах шийдвэрийг яаралтай түгээхэд туслах;
- (4) ИНД-171-ийн дагуу олгосон НХНАТҮБ-ын гэрчилгээ эзэмшигч ашиглахыг зөвшөөрөх хүртэл энэ хэсгийн (1)-д заасан байгууламжийг IFR нислэг хооронд зайчлалаар хангахад ашигладаггүй болохыг бататгах.

**172.113. Зөрчил**

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) ИНД-12-ын зөрчлийг мэдээлэх, шинжлэн шалгах болон тайлан гаргах;
- (2) ИНД-91.431-д шаардсан байгууламжийн доголдлын мэдээг холбогдох АНТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчид дамжуулах.

**172.115. Бүртгэл**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах үйл ажиллагаанд шаардлагатай бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, бүртгэх, хадгалах, хөтлөх, танилцах, устгах тогтолцоо болон журмыг тогтоосон байх үүрэгтэй:

- (1) НХҮ-ний үйл ажиллагааг хангах;
  - (2) осол, эсхүл зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор.
- (b) Энэ зүйлийн (a)-д заасан бүртгэл нь дараах мэдээллийг багтаасан байх ёстой:
- (1) утсан холбооны яриа;
  - (2) радио нэвтрүүлэг болон холбооны яриа;
  - (3) агаар-газрын тоон өгөгдлийн солилцоо;
  - (4) НХҮ-ний ажиглалтын системийн өгөгдөл;
  - (5) стандарт болон давтагдах төлөвлөгөөг багтаасан, хүргүүлсэн нислэгийн төлөвлөгөө;
  - (6) нислэгийн явцын стрип;
  - (7) ажилтны ээлжийн хуваарь;
  - (8) тухайн мэдээллийг дүйцэх хугацаанд цаг уурын, эсхүл НМҮБ хадгалдаг байхаас бусад тохиолдолд, холбогдох цаг уурын болон агаарын навигацийн мэдээлэл;
  - (9) [хүчингүй]

- (10) 172.165-ын дагуу сургалтад хамрагдсан байх шаардлагатай ажилтнуудын дараах дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан бүртгэл:
- (i) хамрагдсан сургалтын үе шат бүр;
  - (ii) зохион байгуулсан сургалтад шаардсан онолын мэдлэгийн шалгалт, эсхүл ур чадварын үнэлгээний дүн.
- (c) Хүсэлт гаргагч нь дараах цахим бүртгэлийг бататгах тогтолцоо болон журмыг тогтоосон байх үүрэгтэй:
- (1) бүх НХУ-ний радио болон утсан холбоо;
  - (2) бүх HF агаар-газрын холбоо;
  - (3) НХУ-ын үйлчилгээгээр хангах, эсхүл дэмжихэд ашигладаг, НХУ-ний ажиглалтын системээс авсан холбогдох бүх өгөгдөл;
  - (4) энэ Дүрэм хүчинтэй болсон өдрөөс хойш үйлчилгээнд шинээр ашиглах аливаа төхөөрөмжийн хяналтыг шилжүүлэх болон хүлээн зөвшөөрөх ажиллагааг утсан холбоогоор хийдэггүй байх.
- (d) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (c)-д заасан цахим бүртгэлийг дараах шаардлага хангасан болохыг бататгах тогтолцоо болон журмыг тогтоосон байх үүрэгтэй:
- (1) стандарт цагийн төхөөрөмж, эсхүл GPS цагийн стандартаар харьцуулан тодорхойлсон, UTC цагийг 5 секундийн нарийвчлалтайгаар зөв заадаг цагийн бүртгэлийг багтаасан байх;
  - (2) дараах аль нэг:
    - (i) дуут холбоо, хэрэв хамааралтай бол, тухайн үйл ажиллагааны нэгжийн нислэгийн хөдөлгөөний ажиглалтын дэлгэцээр харуулж байгаа мэдээллийг хуулбарладаг байх; эсхүл
    - (ii) тухайн хуулбарласан бичлэгийн болон энэ зүйлийн (i)-д шаардсан бичлэг хоорондын ялгааг тодорхойлсон мэдэгдлийг хавсаргасан байх.
- (e) Энэ зүйлийн (d)(2)(ii)-т заасан сонголт нь зөвхөн 1998 оны 1 сарын 1-нээс өмнө ажиглалтад орсон төхөөрөмжид хамаарна.
- (f) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (d)(2)(i)-д шаардсан хуулбарлах ажиллагаанаас бусад тохиолдолд, бүх бичлэг шаардлагатай мэдээллээр хангахад хангалттай болохыг бататгах тогтолцоо болон журмыг тогтоосон байх үүрэгтэй.
- (g) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (b)-д заасан дараахаас бусад бүртгэлийг, тухайн бичилт хийсэн өдрөөс хойш 31 хоног хадгалдаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:
- (1) 2 жил хадгалдаг байх ёстой ээлжийн хуваарь;
  - (2) 2 жил хадгалдаг байх ёстой, 172.121(a)(2) болон (3)-ын шаардлагатай холбоотой бичгэн бүртгэл;
  - (3) холбогдох этгээд нь НХУБ-д ажиллахгүй болсноос хойш 3 жилийн хугацаагаар хадгалдаг байх ёстой, сургалтын бүртгэл.

**172.117. Бүртгэлийн дэвтэр болон үйл ажиллагааны нэгжийн дэвтэр**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараалан дугаарлагдсан хуудастай бүртгэлийн дэвтрийг НХҮ-ний нэгж бүрд болон тухайн үйлчилгээний нэгж нь үйл ажиллагааны тусдаа бие даасан бүстэй тохиолдолд, тухайн үйлчилгээний нэгжийн байрлал бүрд хадгалдаг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

(b) Тухайн журам нь дараах шаардлагыг бататгасан байна:

- (1) бүртгэлийн дэвтрийг тухайн ээлжийн удирдах ажилтан, эсхүл тухайн томилогдсон үйл ажиллагааны нэгжид ажил үүрэг гүйцэтгэж байгаа этгээд хөтөлдөг байх;
- (2) бүртгэлийн дэвтрийг тухайн үйлчилгээний нэгж, эсхүл үйл ажиллагааны нэгжид хяналт хийж байгаа бүх цаг хугацаанд хөтөлдөг байх;
- (3) бүртгэл бүрд тухайн бүртгэлийг хийсэн хугацааг тэмдэглэдэг байх;
- (4) бүртгэлийн дэвтрийн хөтлөлтийг хариуцсан этгээд тухайн ажил үүргийг хүлээж авахдаа гарын үсэг зурж, бичилт хийх ба тухайн ажил үүргээ шилжүүлэхдээ холбогдох бичилтийг бүртгэлийн дэвтэрт оруулдаг байх;
- (5) бүртгэлийн дэвтэрт оруулж байгаа мэдээлэл нь дараах шаардлагыг хангасан байна:
  - (i) он сар өдөр, цаг хугацааны зөв дараалалтайгаар, бэхээр бичих;
  - (ii) баллахгүй, давхардуулахгүй, эсхүл дарж устгахгүй байх;
  - (iii) алдаатай мэдээллийг ганц зураасаар бүхэлд нь дарж залруулдаг байх ба тухайн залруулгыг хийсэн этгээд гарын үсгээр баталгаажуулдаг байх;
- (6) тухайн ээлжийн хяналт хийж эхэлсэн ба дууссан цагийг бүртгэлийн дэвтэрт хөтөлдөг байх, тухайн үйлчилгээг үзүүлэхээр хэвлэн нийтэлсэн цагаас зөрж байгаа бол түүний шалтгааныг заавал бичих;
- (7) бүртгэлийн дэвтэрт хийсэн сүүлчийн бичилт хийсэн өдрөөс хойш 3 жил хадгалдаг байх.

(c) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-д шаардсан бүртгэлийн дэвтэрт, тухайн мэдээлэл байхгүй тохиолдолд үйл ажиллагааны нэгжийн дэвтрийг хадгалдаг болохыг бататгах журмыг тогтоосон байна.

(d) Журам нь үйл ажиллагааны нэгжийн дэвтэр дараах шаардлага хангасан болохыг бататгасан байна:

- (1) дараах нөхцөлийг тогтоох хангалттай мэдээллийг багтаадаг байх:
  - (i) тухайн үйл ажиллагааны нэгжийн үйл ажиллагаа эхэлсэн цаг;
  - (ii) тухайн үйл ажиллагааны нэгжээс үзүүлсэн үйлчилгээ;
  - (iii) тухайн үйлчилгээ үзүүлсэн ажилтны мэдээлэл.
- (2) бичилт хийсэн өдрөөс хойш 31 хоног хадгалдаг байх.

**172.119. Аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ-ний аюулгүйн хамгаалалтын хөтөлбөртэй байна.



(b) НХҮ-ний аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт аливаа эвдрэл, гэмтэл, эсхүл хууль бус үйлдэл нь агаарын хөлгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй тохиолдолд, хүсэлт гаргагчийн ажиллуулж байгаа НХҮ-ний нэгжийн эвдрэл, гэмтэл, эсхүл хууль бус үйлдлийн эрсдэлийг багасгах зорилгоор аюулгүйн хамгаалалтын бодит шаардлага, дадлага сургуулилт болон журмыг заасан байна.

(c) Энэ зүйлийн (b)-гийн ерөнхий шаардлагаар хязгаарлагдахгүйгээр, аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт дараах шаардлагыг бататгах зорилгоор, шаардлагатай байж болох аюулгүйн хамгаалалтын бодит шаардлага, дадлага сургуулилт болон журмыг заасан байна:

- (1) зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэх зорилгоор хүсэлт гаргагчийн ажиллуулж байгаа НХҮ-ний байнгын суурин байгууламжийн орох хаалга нь байнгын нэвтрэх хяналттай болохыг бататгадаг байх;
- (2) үүрэг гүйцэтгэж байгаа ажилтныг хамгаалах;
- (3) НХҮ-ний нэгжийн эсрэг тэсрэх бөмбөгөөр заналхийлэх, эсхүл бусад заналхийллийн зөрчлийн үед дагаж мөрддөг байх;
- (4) хяналтгүй орхисон НХҮ-ний нэгжийн барилга байгууламжид хууль бусаар нэвтрэх, эсхүл үйл ажиллагаанд нөлөөлөх үйлдлийг илрүүлдэг болохыг бататгах зорилгоор хяналт тавьдаг байх.

#### **172.121. Үйлчилгээний тасралт**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-12-ын шаардлагаас гадна дараах журмыг тогтоосон байна:

- (1) аюулгүй байдалд нөлөөлж болох, НХҮ-ний хангалтын аливаа төлөвлөсөн тасралтыг Даргад мэдээлэх;
- (2) НХҮ-ний хангалтын төлөвлөгдөөгүй тасралтыг шинжлэн шалгах;
- (3) тухайн тасралт нь нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлсөн, эсхүл нөлөөлж болох бол, НХҮ-ний төлөвлөгдөөгүй тасралттай холбоотой нөхцөл байдлыг тухайн хэрэг явдал гарснаас хойш 48 цагийн дотор Даргад мэдээлэх.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу мэдээлэх ёстой тасралт нь дараах хэвийн бус ажиллагаа багтаах ба гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй:

- (1) зарласан хяналтын цаг эхэлснээс хойш 15 минутын дотор хяналтыг эхлүүлж чадахгүй байх;
- (2) НХҮ-ний хэвийн хангалтад гарсан 10-аас дээш минутын аливаа тасалдал;
- (3) зарласан хяналтын цаг дуусахаас 30-аас дээш минутын өмнө хяналтыг зогсоох.

#### **172.123. Аюулгүй байдлын удирдлага**

НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-103-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.

**172.125. НХҮБ-ын Ерөнхий заавар**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад заавар нь дараах шаардлагыг багтаасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
  - (i) тухайн байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрэм болон бусад холбогдох Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах;
  - (ii) тухайн байгууллагын ажилтнууд түүнийг байнга дагаж мөрддөг байх;
- (1A) 172.123-т шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:
  - (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
  - (ii) НХҮБ-ын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 172.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал, нэр;
- (3) 172.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын дараах үүрэг, хариуцлага:
  - (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
  - (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;
- (4) 172.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл удирдах ажилтнуудын болон энэ зүйлийн (a)(5)(i)-д заасан байрлал бүрийг хамарсан үүрэг хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (5) нэгээс дээш НХҮ-ний нэгжээс НХҮ үзүүлж байгаа тохиолдолд, дараах мэдээллийг заасан хүснэгт:
  - (i) НХҮ-ний нэгжийн байрлал;
  - (ii) үйлчилгээ үзүүлж байгаа аэродром, эсхүл агаарын зай;
  - (iii) үзүүлэх үйлчилгээ.
- (6) НХҮ-ний нэгж бүрд ажиллах тухайн хүсэлт гаргагчийн ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (7) 172.51(b)-д шаардсан, ажилтны ур чадвар, мэргэшил, үйл ажиллагааны практик дадлын хадгалалт болон эрүүл мэндийн байдлын журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (8) 172.53-т шаардсан, НХҮ-ний ажилтны сургалт, үнэлгээ болон НХҮ-ний сургалтын ажилтны мэргэшлийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (9) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
- (10) 172.57 (b)(5)(i) ба 172.57(c)(2)(i)-ийн шаардлагыг хангуулах зорилгоор ашиглах дэлгэцийн системийн тодорхойлолт;
- (11) 172.59-д шаардсан, үйлчилгээний цаг, НХҮ-г тогтоох болон аливаа шилжилтийн зохицуулалтын мэдээлэл;
- (12) 172.61-д шаардсан, ээлжийн зохицуулалтын журам;

- (13) 172.63-т шаардсан, баримт бичгийн хяналтын журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (14) 172.65-д шаардсан, нөөц төлөвлөгөө;
- (15) 172.67-д шаардсан, зохицуулалтын шаардлагын журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (16) 172.69-д шаардсан, байгууламжийн төлөв байдлыг мэдээлэх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (17) 172.71-д шаардсан, нислэгийн мэдээллийн ерөнхий шаардлагын тогтолцоо болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (18) 172.73-т шаардсан, цаг уурын мэдээлэл болон мэдээлэх тогтолцоо болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (19) 172.75-д шаардсан, бүсийн болон ойртолтын удирдлагын үйлчилгээний тогтолцоо болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (20) 172.77-д шаардсан, аэродромын удирдлагын үйлчилгээ үзүүлэх тогтолцоо болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (21) 172.79-д шаардсан, хяналттай нислэг болон идэвхтэй байгаа тусгай зориулалтаар ашиглах агаарын зайн зайчлалын тогтолцоо болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (22) 172.81-д шаардсан, удирдлагын хариуцлагын журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (23) 172.83-т шаардсан, давуу эрх олгох журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (24) 172.85-д шаардсан, хөдөлгөөний урсгалын зохицуулалтын журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (25) 172.87-д шаардсан, НХУ-ын зөвшөөрлийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (26) 172.89-д шаардсан, аяллын түвшнийг хуваарилах журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (27) 172.91-д шаардсан, НХУ-ын зөвшөөрлөөс хазайх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (28) 172.93-т шаардсан, нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (29) 172.95-д шаардсан, аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (30) 172.97-д шаардсан, анхааруулах үйлчилгээ үзүүлэх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (31) 172.99-д шаардсан, нислэгийн төлөвлөгөө хүлээн авах болон хэрэгжүүлэх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (32) 172.101-д шаардсан, цаг хугацааны журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (33) 172.103-т шаардсан, алтиметрийн тохируулга хийх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (34) 172.105-д шаардсан, радио болон утсан холбооны журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (35) 172.107-д шаардсан, НХУ-ний ажиглалтын үйлчилгээ үзүүлэх журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (36) 172.109-д шаардсан, агаарын хөлгийн онцгой нөхцөлийн болон хэвийн бус үйл ажиллагааны журмын дэлгэрэнгүй мэдээлэл;

- (37) 172.111-д шаардсан, ноцтой зөрчил, эсхүл ослын дараах арга хэмжээний журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (38) 172.113-т шаардсан, зөрчлийн журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (39) 172.115-д шаардсан, бүртгэлийн бүрдүүлэлт, зохицуулалтын тогтолцоо болон журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (40) 172.117-д шаардсан, бүртгэлийн дэвтэр болон үйл ажиллагааны нэгжийн дэвтрийг хадгалах журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (41) 172.119-д шаардсан, аюулгүйн хамгаалалтын зохицуулалтын хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (42) 172.121-д шаардсан, үйлчилгээний тасралтын журмын дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (43) [хүчингүй]
  - (44) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.
- (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

## **С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага**

### **172.151. Байнгын хэрэгжилт**

НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) зөвхөн тодорхой байрлалд хамаарах зааврыг үндсэн байрлал болон холбогдох үйлчилгээний нэгжид хадгалсан байх шаардлагатай байхаас бусад тохиолдолд, Ерөнхий заавартаа заасан НХҮ-ний нэгж бүрд, тухайн зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгалдаг байх;
- (2) Ерөнхий заавартаа дэлгэрэнгүй заасан бүх журам болон стандартыг дагаж мөрддөг байх;
- (3) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг, шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд ашиглах боломжтой байлгах;
- (4) энэ Дүрмийн дагуу гэрчилгээжүүлэлтэд тогтоосон В Бүлгийн шаардлага болон стандартыг байнга хангадаг байх;
- (5) САА 24172/01 маягтад шаардсан үйлчилгээ эрхлэх хаяг, утасны дугаар, эсхүл факсын дугаарын аливаа өөрчлөлтийг Даргад нэн даруй мэдэгддэг байх.

### **172.153. Үйл ажиллагааны заавар**

(a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, түүний ажилтан дагаж мөрдөхөд зориулан, Ерөнхий заавартаа заасан тухайн үйлчилгээний үйл ажиллагааны заавар, эсхүл заавруудын тогтолцоогоор хангана.

(b) НХҮ-ний нэгээс дээш үйлчилгээг, эсхүл нэгээс олон байрлалаас НХҮ үзүүлэхээр гэрчилгээжсэн эзэмшигч нь суурь үндсэн зааврыг тухайн үйлчилгээ, эсхүл байрлал бүрийн онцлогт тохирсон зааврын нэмэлтийн хамт хэвлэн нийтэлж болно .

**172.155. Туршилт**

(а) Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзвэл, НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлтийг үндэслэн, дараах туршилтыг гүйцэтгэх зөвшөөрлийг олгож болно:

- (1) босоо зайчлалын минима; эсхүл
- (2) стандарт хэвшмэл хэллэг; эсхүл
- (3) НХҮ-ний ажиглалтын үйлчилгээний журам.

(b) Туршилт нь нэг удаа, 3 сараас дээшгүй байхаар Даргаас зөвшөөрөл олгогдсон байх ба гэрчилгээ эзэмшигчээс хугацааг сунгах хүсэлтийг бичгээр гаргасан тохиолдолд Дарга тухайн зөвшөөрлийг дахин нэг удаа, 3 сарын хугацаагаар сунгаж болно.

(c) Дарга шаардлагатай гэж үзвэл, тухайн туршилтыг хугацаанаас нь өмнө аль ч цаг хугацаанд зогсоож болно.

**172.157. НХҮ-ын зөвшөөрөл олгохоос татгалзах**

(а) Аэродромын удирдлагын үйлчилгээ үзүүлдэг НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараахаас бусад тохиолдолд, үйлчилгээний төлбөрөө барагдуулаагүй шалтгаанаар тухайн агаарын хөлгийн нисгэгчид НХҮ-ын зөвшөөрөл олгохоос татгалзах эрхгүй:

- (1) тухайн агаарын хөлөг газарт байх;
- (2) тухайн зөвшөөрөл нь маневрын талбайд нэвтрэх зөвшөөрөл байх.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь маневрын талбайд НХҮ-ын зөвшөөрөлгүй нэвтэрсэн аливаа агаарын хөлгийг НХҮ-ын хэвийн үйлчилгээгээр үргэлжлүүлэн хангана.

**172.159. VFR нислэгийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх**

Ойртолтын удирдлагын үйлчилгээ, эсхүл аэродромын удирдлагын үйлчилгээ үзүүлдэг НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн аюулгүй байдлын зорилгоор, удирдлагын зоонд аливаа, эсхүл бүх хяналттай VFR нислэгийн үйл ажиллагааг түдгэлзүүлж болно.

**172.161. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт**

(а) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг тухайн байгууллага болон үйлчилгээний тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийдэг болохыг бататгах үүрэгтэй.

(b) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, Ерөнхий заавартаа оруулсан нэмэлт өөрчлөлт нь дараах шаардлагад нийцсэн болохыг бататгах үүрэгтэй:

- (1) энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангадаг байх;
- (2) Ерөнхий зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрддөг байх.

(c) Тухайн эзэмшигчийн үйл ажиллагааны заавар, эсхүл заавруудын хувьд, эзэмшигч дараах хугацаанд Даргад хүргүүлэх ёстой байхаас бусад тохиолдолд, Ерөнхий заавартаа нэмэлт өөрчлөлт оруулсны дараа НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа оруулсан нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй:

- (1) нэмэлт өөрчлөлт бүрийн хувийг хүчинтэй болох өдрөөс өмнө, 15-аас доошгүй хоногт;
  - (2) шуурхай, эсхүл яаралтай оруулах нэмэлт өөрчлөлтийг хойшлуулалгүй, түүний хүчинтэй болох өдрөөс өмнө.
- (d) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхийн өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:
- (1) Гүйцэтгэх захирал;
  - (2) жагсаалтад заасан удирдах ажилтан, эсхүл ажилтнууд;
  - (3) зэргэлдээх агаарын зайг хариуцсан Улсын үзүүлдэг НХҮ-нд сөргөөр нөлөөлөхүйц нислэгийн хөдөлгөөний зохицуулалтын аливаа асуудал;
  - (4) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хэрэв тухайн өөрчлөлт нь бодит өөрчлөлт бол.
- (e) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл түүнийг хийсний дараа НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх ёстой нөхцөлийг Дарга тогтоож болно.
- (f) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e)-гийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.
- (g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол, НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.
- (h) Нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч Ерөнхий заавартаа оруулах үүрэгтэй.

### **172.163. Үйлчилгээг зогсоох, эсхүл шилжүүлэх**

- (a) Аливаа НХҮ-г бүрмөсөн зогсоохыг хүсэж байгаа НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь 90-ээс доошгүй хоногийн өмнө мэдэгдлийн саналыг Даргад хүргүүлэх ба тухайн мэдэгдэлд уг үйлчилгээгээ зогсоох шийдвэрт хүргэсэн хүчин зүйлийг багтаасан байна.
- (b) Аливаа НХҮ-ний үйл ажиллагааны ажлын цагийн хуваарийг багасгахыг зорьж байгаа НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь, ажлын цагаа багасгахаар санал болгосон урьдчилсан мэдэгдэл болон шалтгаанаа Даргад хүргүүлнэ.
- (c) Аливаа НХҮ-г цаашид үзүүлэхээ зогсоож байгаа НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь 172.59(b)-д шаардсан шилжилтийн зохицуулалтын бэлтгэл болон хэрэгжүүлэлтэд саад учруулахгүй байх үүрэгтэй.

### **172.165. Аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөр**

- (a) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн хүсэлт гаргагчийн үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллаж байгаа ажилтнуудыг тэдний үйл ажиллагаатай холбоотой аюулгүйн хамгаалалтын зохих түвшний мэдлэгтэй болохыг бататгах сургалтын хөтөлбөр болон журмыг тогтоосон байх үүрэгтэй.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан сургалтын хөтөлбөр нь дараах сургалт, шалгалт болон үнэлгээг багтаасан байх ёстой:
- (1) анхан шатны болон давтан сургалтын холбогдох үе шат;

- (2) тухайн зохион байгуулдаг сургалтад хамаарах онолын мэдлэгийн шалгалт болон ур чадварын үнэлгээ.
- (c) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b)(1)-д шаардсан үе шат бүр нь дараах шаардлагыг хангасан болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй:
- (1) Даргын хүлээн зөвшөөрөхүйц хичээлийн сэдвийн задаргааг багтаасан байх;
  - (2) тухайн гэрчилгээ эзэмшигчийн зөвшөөрсөн этгээдийн зохион байгуулсан болон чиглүүлсэн хэлбэрээр хийгдсэн байх.
- (d) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)-ийн дагуу сургалтад хамрагдсан байх шаардлагатай этгээдийг тухайн сургалтын хөтөлбөрийн давтан сургалтын үе шатанд 3 жилээс ихгүй үечлэлтэй хамрагддаг болохыг бататгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

## **D Бүлэг - Бусад НХҮ**

### **172.201. Ерөнхий зүйл**

- (a) Аливаа этгээд, нисэхтэй холбоотой аливаа үйлчилгээг 172.11(a)(7)-д заасан НХҮ-нд хамаарах эсэхийг тогтоолгох зорилгоор санал болгож байгаа үйлчилгээний тодорхойлолт болон дэлгэрэнгүйг багтаасан хүсэлтийг Даргад бичгээр гаргаж болно.
- (b) Дарга шаардлагатай гэж үзсэн этгээдтэй зөвлөлдөн, нисэхтэй холбоотой аливаа үйлчилгээг 172.11(a)(7)-д заасан НХҮ-нд хамаарах эсэхийг тогтоож болно.

### **172.203. Гэрчилгээний шаардлага**

Энэ Бүлгийн дагуу олгосон НХҮБ-ын гэрчилгээний эрх болон хязгаарлалтын хүрээнд зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд 172.201-ийн дагуу НХҮ гэж Даргын тогтоосон үйлчилгээг үзүүлэхгүй.

### **172.205. Хүсэлт гаргах**

- (a) 172.11(a)(7)-д заасан НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА 24172/01 маягыг дараах мэдээллийн хамт Даргад хүргүүлнэ:
- (1) хүсэлт гаргагчийн байгууллагын бүтэц зохион байгуулалт болон Даргын шаардаж болох, тухайн НХҮ-ний талаарх мэдээлэл;
  - (2) зохих төлбөрийн баримт.

### **172.207. Гэрчилгээ олгох**

- (a) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь 172.11(a)(7)-д заасан НХҮ эрхлэхээр, НХҮБ-ын гэрчилгээ эзэмших эрхтэй:
- (1) хүсэлт гаргагч нь тохирох зөв хүн байх;
  - (2) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

(b) Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзсэн аливаа нөхцөлийг гэрчилгээнд хавсаргаж болно.

#### **172.209. Үйл ажиллагааны нөхцөл**

Энэ Бүлгийн дагуу олгосон гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээнд хавсаргасан нөхцөлийн дагуу НХҮ-г үзүүлэх үүрэгтэй.

## **Е Бүлэг - Зайчлалын шалгуур болон минима**

#### **172.251. Босоо зайчлал**

Хяналттай агаарын зайд, дараах тохиолдолд босоо зайчлалыг 150 м (500 ft) хүртэл багасгаж болно:

- (1) агаарын хөлөг нь хоёулаа дунд, эсхүл хөнгөн дагалдах хуйлралын категорид хамаардаг байх;
- (2) нам өндөрт нисэж байгаа агаарын хөлөг нь VFR, эсхүл тусгай VFR нислэгийг 1350 м (4500 ft), эсхүл түүнээс нам өндөрт гүйцэтгэж байгаа.

#### **172.253. Хосолмол ил харааны зайчлал**

Аэродромын хөдөлгөөний удирдагч нь хангалттай зайчлал хадгалахад шаардлагатай зааварчилгааг багтаасан, газарзүйн болон ил харааны хосолмол зайчлалыг дараах агаарын хөлөг хооронд тогтоож болно:

- (1) агаарын хөлөг нь аэродромын хөдөлгөөний удирдагчийн хараанд тогтмол байгаа ба тухайн аэродромоос 18.5 км-ийн (10 NM) дотор байгаа;
- (2) агаарын хөлөг нь аэродромын хөдөлгөөний удирдагчийн хараанд байхгүй хэдий ч, түүний бодит байршил нь зөвшөөрөгдсөн НХҮ-ний ажиглалтын систем ашиглан, эсхүл нисгэгчийн байршлын мэдээллээр тогтоогдсон.

#### **172.255. Аэродромын ойролцоох бүсийн гаднах ил харааны зайчлал**

Дараах тохиолдолд, өдрийн цагаар зайчлалын минима-г ил харааны зайчлалыг зөвшөөрснөөр багасгаж болно:

- (1) нисгэгч тусгайлан хүсэлт гаргасан;
- (2) агаарын хөлөг бүр нь дараах хяналтад байгаа:
  - (i) ижил үйл ажиллагааны нэгжийн; эсхүл
  - (ii) хоёр аэродромын хөдөлгөөний удирдагч зөвшөөрсөн бол зэргэлдээх үйл ажиллагааны нэгжийн.
- (3) агаарын хөлөг бүр VMC нөхцөлд хэвээр байх;
- (4) дараах тохиолдолд:
  - (i) агаарын хөлөг бүр нь хоёр агаарын хөлгийн нисгэгчид хоёуланд нь байнга харагдаж байгаа ба тухайн хоёр нисгэгч ил харааны зайчлал ашиглахыг зөвшөөрсөн; эсхүл



- (ii) дагаж байгаа агаарын хөлгийн нисгэгч нь урдаа байгаа агаарын хөлгийг харагдах орчинд байгааг мэдээлсэн ба урдаа байгаа агаарын хөлгөөс ил харааны зайчлалыг хадгалж чадах.

### **172.257. Тууш зайчлалыг хугацаагаар тогтоох**

Хоёр агаарын хөлгийг, мэдэгдэхийг шаардсан ижил чиглэл дээр болон NDB, VOR, эсхүл VORTAC-ын эсрэг талд байгаа агаарын хөлгийг зайчлах үед, дараах шаардлагыг хангасан тохиолдолд 5 минутын минимум тууш зайчлалыг тогтоож болно:

- (1) нэг агаарын хөлөг нь түвшнээ хадгалан чиг шулуун нислэгт байгаа ба нөгөө агаарын хөлөг нь босоо зайчлалыг хангахаар өндөр авч байгаа, эсхүл алдаж байгаа;
- (2) урд байгаа агаарын хөлөг нь NDB, VOR, эсхүл VORTAC-ыг 5-аас доошгүй минутын өмнө өнгөрсөн;
- (3) дагаж байгаа агаарын хөлгөөс NDB, VOR, эсхүл VORTAC дээр хүрч очоогүй болохыг бататгасан мэдээллийг авсан.

### **172.259. Тууш зайчлалыг зайгаар тогтоох**

(a) Тухайн зайчлалыг хоёр агаарын хөлгөөс DME-гийн заалтыг ойр ойрхон, дараалан асуудаг тохиолдолд, ижил чиглэлээр өндөр авч байгаа, эсхүл өндөр алдаж байгаа агаарын хөлөг хооронд 37 км-ийн (20 NM) минимум зайчлалаар хангаж болно.

(b) Дараах тохиолдолд 18.5 км-ийн (10 NM) минимум зайчлалаар хангаж болно:

- (1) дараах шаардлагыг хангасан үед, ижил чиглэлээр өндөр авч, эсхүл өндөр алдаж байгаа агаарын хөлөг хооронд:
  - (i) урд байгаа агаарын хөлөг нь дагаж байгаа агаарын хөлгөөс 37 км/цаг (20 knots), эсхүл түүнээс илүү жинхэнэ хурд хадгалж байх;
  - (ii) гулгах зайн (slant-range) нөлөөг тооцсон байх;
  - (iii) хоёр агаарын хөлгөөс DME-гийн заалтыг ойр ойрхон, дараалан асууж тухайн зайчлалыг хангадаг байх; эсхүл
- (2) урд байгаа агаарын хөлгийн DME-гийн сүүлчийн мэдээллийн өмнө дагаж байгаа агаарын хөлөгт 18.5 км-ийн (10 NM) тууш зайчлалыг хадгалах зааварчилгаа өгсөн тохиолдолд, тууш зайчлалаас босоо зайчлал руу шилжих үед; эсхүл
- (3) ижил DME ашиглан, тухайн нуман дээр байгаа агаарын хөлгөөс, ард байгаа ба DME, эсхүл TACAN нумаас нисэн гарч байгаа агаарын хөлгийг зайчлах үед.

### **172.261. Хажуугийн зайчлал**

(a) Дараах тохиолдолд, хажуугийн зайчлалаар хангахдаа DME-гийн зайн оронд GPS зайг ашиглаж болно:

- (1) хоёр агаарын хөлөг нь ижил навигацийн туслах төхөөрөмжид суурилсан чиглэлээр нисэж байгаа;
- (2) тухайн GPS зай нь хажуугийн зайчлалд суурилсан ижил навигацийн туслах төхөөрөмжөөр мэдээлэгдсэн.

(b) Хажуугийн зайчлалыг зөвхөн ИНД-173-ын дагуу олгосон ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн баталсан шалгуур болон минима-гийн дагуу хэрэглэж болно.

#### **172.263. Хэрэглэлийн ойртолтын үеийн агаарын хөлөг хоорондын зайчлал**

Эхний агаарын хөлөг дараах шаардлагыг хангасан бол дагаж байгаа агаарын хөлөгт хэрэглэлээр ойртолт үйлдэх зөвшөөрөл олгож болно:

- (1) ойртолтоос 2-т гарах тохиолдолд зайчлалыг хадгалах нөхцөл хангагдсан үед ILS, эсхүл LOC approach дундын маркер, эсхүл хос NDB-гийн төгсгөлийн NDB, эсхүл VOR/NDB approach-ыг давсан; эсхүл
- (2) төгсгөлийн ойртолтын үе шатанд байх ба дагаж байгаа агаарын хөлөг эхний ойртолт эхлүүлдэг радио навигацийн туслах төхөөрөмжийг давсан ба ойртолтоос 2-т гарах тухайн журам нь эхний, дунд, төгсгөлийн ойртолтын журмаас тусдаа байх.

#### **172.265. НХҮ-ний ажиглалтын үйлчилгээгээр хангах үеийн багасгасан зайчлал**

Doc 4444, 8.7.4.2-ын дагуу Дарга Doc 4444, 8.7.4.1-д заасан стандарт 9.3 км-ийн (5 NM) минимум зайчлалыг багасгахыг зөвшөөрч болно.

#### **172.267. НХҮ-ний ажиглалтын үйлчилгээгээр танигдаагүй хяналттай нислэгээс зайчлах**

(a) Дараах нөхцөлд 9.3 км-ийн (5 NM) минимум зайчлалыг ашиглаж болно:

- (1) Doc 4444 Part VI 7.3.7 (a) болон (b)-гийн дагуу НХҮ-ний ажиглалтын системийн бүсэд орж байгаа, эсхүл орох гэж байгаа таньж тогтоогдсон агаарын хөлөг болон танигдаагүй хяналттай нислэг хооронд; эсхүл
- (2) урд байгаа агаарын хөлгийн НХҮ-ний ажиглалтын системийн бүрхүүлийг өнгөрөх байршлын өмнө, дагаж байгаа агаарын хөлөг нь босоо зайчлалыг хадгалж чадах тохиолдолд, дагаж байгаа таньж тогтоогдсон агаарын хөлөг болон НХҮ-ний ажиглалтын системийн бүрхүүлээс гарсан, өмнө нь таньж тогтоогдсон агаарын хөлөг хооронд; эсхүл
- (3) өмнө нь таньж тогтоогдсон агаарын хөлөг НХҮ-ний ажиглалтын системийн бүрхүүлээс гарсан байршлыг таньж тогтоогдсон агаарын хөлөг өнгөрсөн тохиолдолд, эсрэг чиглэлд нисэж байгаа агаарын хөлөг хооронд; эсхүл
- (4) НХҮ-ний ажиглалтын системийг ашиглан таньж тогтоогдсон агаарын хөлөг болон танигдаагүй хяналттай VFR нислэг хооронд тогтоож болно.

#### **172.269. НХҮ-ний ажиглалтын үйлчилгээний хүлээлтэд байгаа агаарын хөлгөөс зайчлах**

НХҮ-ний ажиглалтын системийг ашиглан, хүлээлтэд байхгүй таньж тогтоогдсон агаарын хөлөг болон хүлээлтэд байгаа агаарын хөлгийн хувийн таних тэмдэг алдагдсанаас үл хамааран, хүлээлтэд байгаа бусад таньж тогтоогдсон агаарын хөлөг хооронд 9.3 км-ийн (5 NM) минимум зайчлалыг ашиглаж болно.

**172.271. Жагсаалын нислэг**

Дараах тохиолдолд жагсаалын нислэгт байгаа агаарын хөлөг хооронд зайчлал тогтоохгүй:

- (1) жагсаалын ахлагч НХУ-д тухайн нислэгийн өмнө урьдчилан мэдэгдсэн; эсхүл
- (2) тухайн нислэг нь аюулд өртсөн агаарын хөлөг болон түүний дагалдагчаас бүрдсэн.

**172.273. ХБЗ-ны багасгасан зайчлалын ерөнхий шаардлага**

Энэ дүрмийн 172.275 - 172.279-д заасан ХБЗ-ны багасгасан зайчлалыг дараах тохиолдолд тогтоож болно:

- (1) алсын барааны харагдац 5 км-ээс багагүй байх ба нисгэгч нь тухайн ХБЗ-ны нөхцөлд урьдчилан үнэлгээ хийх боломжтой;
- (2) ХБЗ-ны хур тунадас нь тормозлох үйлдэлд сөргөөр нөлөөлөхгүй байж болох;
- (3) тухайн заасан тууш зайг аэродромын хөдөлгөөний удирдагчийн тогтоосон тэмдэглэгээ, эсхүл онцлог шинжээр баримжаалан хялбар тодорхойлох боломжтой;
- (4) холбогдох нислэгийн хөдөлгөөний мэдээлэл өгөгдсөн;
- (5) 172.275(1)-д зааснаас бусад тохиолдолд, зайчлалыг өдрийн цагаар тогтоосон.

**172.275. Нисэн гарах нислэг хоорондын ХБЗ-ны багасгасан зайчлал**

Энэ дүрмийн 172.273-ын нөхцөлийг хангасан бол дараах тохиолдолд, дагаж байгаа агаарын хөлөгт хөөрөлт үйлдэх зөвшөөрөл өгч болно:

- (1) тухайн ХБЗ нь 1800 м-ээс урт ба урд байгаа агаарын хөлөг нь агаарт хөөрсөн бөгөөд дагаж байгаа агаарын хөлгийн урд 1800 м-ээс доошгүй зайтай цэгт хүрсэн; эсхүл
- (2) хоёр агаарын хөлгийн MCTOW нь 7000 кг, эсхүл түүнээс бага жинтэй ба урд байгаа агаарын хөлөг агаарт хөөрсөн бөгөөд дагаж байгаа агаарын хөлгийн урд 1000 м-ээс доошгүй зайтай цэгт хүрсэн; эсхүл
- (3) хоёр агаарын хөлгийн MCTOW нь 2300 кг, эсхүл түүнээс бага жинтэй ба урд байгаа агаарын хөлөг агаарт хөөрсөн бөгөөд дагаж байгаа агаарын хөлгийн урд 600 м-ээс доошгүй зайтай цэгт хүрсэн; эсхүл
- (4) тухайн агаарын хөлөг нь хэт хөнгөн агаарын хөлөг ба урд байгаа агаарын хөлөг нь агаарт хөөрсөн.

**172.277. Нисэн ирэх, нисэн гарах нислэг хоорондын ХБЗ-ны багасгасан зайчлал**

Энэ дүрмийн 172.273-ын нөхцөлийг хангасан бол дараах тохиолдолд, нисэн ирж байгаа агаарын хөлөгт ХБЗ-ны босгыг буулт үйлдэхээр давах зөвшөөрөл олгож болно:

- (1) нисэн гарч байгаа агаарын хөлөг агаарт хөөрсөн бөгөөд нисэн ирж байгаа агаарын хөлгийн буулт үйлдэх төлөвлөсөн цэгийн гадна хүрсэн; эсхүл
- (2) хоёр агаарын хөлгийн MCTOW нь 2300 кг, эсхүл түүнээс бага жинтэй ба нисэн гарч байгаа агаарын хөлөг хурдаа авч, нисэн ирж байгаа агаарын хөлгийн урд 600 м-ээс доошгүй зайтай цэгт хүрсэн.

**172.279. Нисэн ирэх нислэг хоорондын ХБЗ-ны багасгасан зайчлал**

Энэ дүрмийн 172.273-ын нөхцөлийг хангасан бол, хоёр агаарын хөлөг нь дараах МСТOW-той тохиолдолд, дагаж байгаа агаарын хөлөгт ХБЗ-ны босгыг буулт үйлдэхээр давах зөвшөөрөл олгож болно:

- (1) 7000 кг, эсхүл түүнээс бага жинтэй ба урд байгаа агаарын хөлөг нь:
  - (i) буулт үйлдсэн;
  - (ii) зогсохгүйгээр, эсхүл буцаж эргэхгүйгээр ХБЗ-ыг чөлөөлөх эргэлтийг хийж эхэлсэн; эсхүл
- (2) 2300 кг, эсхүл түүнээс бага жинтэй ба урд байгаа агаарын хөлөг нь:
  - (i) буулт үйлдсэн;
  - (ii) буцаж эргэхгүйгээр ХБЗ-ыг чөлөөлж чадах;
  - (iii) аэродромын хөдөлгөөний удирдагчийн дүгнэлтээр, дагаж байгаа агаарын хөлгийн урд байгаа мөргөлдөх эрсдэлгүй цэгт хүрсэн.

**172.281. Зэрэгцээ ХБЗ-ны үйл ажиллагаа**

Зэрэгцээ, ижил чиглэлтэй ХБЗ-ны үйл ажиллагааг өдрийн цагаар дараах тохиолдолд зөвшөөрч болно:

- (1) аэродромын удирдлагын үйлчилгээний нэгж болон аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь нэг этгээд, эсхүл тухайн үйл ажиллагааны талаар тэдний хооронд байгуулсан гэрээтэй байх;
- (2) алсын барааны харагдац нь 5 км-ээс доошгүй байх;
- (3) аль ч ХБЗ нь тунадсаар сөргөөр нөлөөлөгдөөгүй байх;
- (4) хоёр агаарын хөлөг нь аэродромын удирдлагатай хоёр талын радио холбоотой байх;
- (5) холбогдох нислэгийн хөдөлгөөний мэдээлэл өгөгдсөн байх;
- (6) зэргэлдээх ХБЗ-ны босго нь андуурагдахааргүй тогтоогдсон байх;
- (7) дараах аль нэг шаардлага хангагдсан байх:
  - (i) хоёр ХБЗ-ны зэргэлдээх босго хоорондоо 165 м-ээс багагүй зайтай; эсхүл
  - (ii) хоёр агаарын хөлгийн МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс бага жинтэй ба хоёр ХБЗ-ны зэргэлдээх босго хоорондоо 90 м-ээс багагүй зайтай; эсхүл
  - (iii) хоёр агаарын хөлгийн МСТOW нь 2300 кг, эсхүл түүнээс бага жинтэй ба хоёр ХБЗ-ны зэргэлдээх босго хоорондоо 60 м-ээс багагүй зайтай.

**172.283. Агаарт түлш юүлэх агаарын хөлгийн зайчлал**

Агаарт түлш юүлж байгаа агаарын хөлгөөс дараах минимум зайчлалыг хадгална:

- (1) хэвтээ чиглэлд 9.3 км (5 NM); эсхүл
- (2) босоо чиглэлд 600 м (2000 ft); эсхүл
- (3) доор байгаа агаарын хөлөг түлш юүлж байгаа бөгөөд 8850 м-ээс (FL290) доор нислэгийн түвшинд байгаа үед, босоо чиглэлд 300 м (1000 ft).

**172.285. Цэргийн агаарын хөлгийн зайчлал**

НХҮ-ний нэгж нь Монгол Улсын Зэвсэгт хүчинтэй, эсхүл багасгасан цэргийн зайчлалыг ашиглахыг зөвшөөрсөн гэрээг гадаадын цэргийн эрх бүхий байгууллагатай байгуулаагүй бол, дараах тохиолдолд энэ Дүрэмд заасан зайчлалын шалгуур болон минима нь цэргийн агаарын хөлөгт хамаарна:

- (1) цэргийн агаарын хөлөг хооронд байх;
- (2) оролцож байгаа агаарын хөлгийн нисгэгч зөвшөөрсөн;
- (3) тухайн бичгээр үйлдсэн гэрээний дагуу байх.

**172.287. Нисэн гаргах IFR нислэг хоорондын зайчлал**

Дараах IFR нислэг гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт хөөрөлт үйлдэх зөвшөөрөл олгож болно, хэрэв:

- (1) үндсэн нисэн гарах чиглэл нь эхний агаарын хөлгийн нисэн гарсан чиглэлээс 30°-аар ялгаатай ба ил харааны ажиглалтаар тухайн аэродромын хөдөлгөөний удирдагч эхний агаарын хөлгийг:
  - (i) дагаж байгаа агаарын хөлгийн нисэн гарах чиглэлийг чөлөөлөх зорилгоор эргэлт хийсэн болохыг бататгасан бол; эсхүл
  - (ii) дагаж байгаа агаарын хөлгөөс хангалттай зайчлалтай байх цэгт хүрсэн болохыг бататгасан бол, эсхүл
- (2) үндсэн нисэн гарах чиглэл нь эхний агаарын хөлгийн нисэн гарсан чиглэлээс 20°-аар ялгаатай ба:
  - (i) хөөрөлт үйлдэхэд ашигласан ХБЗ-ны төгсгөлөөс 1.86 км-ийн (1 NM) зайд НХҮ-ний ажиглалтын системийг ашиглан таньж тогтоож болох бол;
  - (ii) эхний агаарын хөлөг нь дагаж байгаа агаарын хөлгөөс 1.86 км-ийн (1 NM) өмнө байгаа ба ил хараагаар, эсхүл НХҮ-ний ажиглалтын системийг ашиглан дагаж байгаа агаарын хөлгийн нисэн гарах чиглэлийг чөлөөлөн эргэлт хийсэн болохыг бататгасан бол.

**172.289. Нисдэг тэрэг болон хөдөлгүүргүй агаарын хөлөг**

Аюулгүй байдлыг алдагдуулахгүй байх нөхцөлийг хангасан бол, нисдэг тэрэг болон хөдөлгүүргүй агаарын хөлгийн тодорхой үйл ажиллагааны үзүүлэлтийг тооцон үзэж ИНД-172.77(а)(4)-д шаардсан ХБЗ-ны зайчлалаас чөлөөлдөг, эсхүл өөрчилдөг байж болно.

**172.291. Дагалдах хуйлралын зайчлал**

Дагалдах хуйлралын зайчлалаас чөлөөлөгдөх нисгэгчийн тусгайлан гаргасан хүсэлтийг дараах тохиолдолд зөвшөөрч болно:

- (1) нислэгийн хөдөлгөөний удирдагч нь тухайн нисгэгчид дагалдах хуйлралын зайчлалаас чөлөөлөгдөх хүсэлт гаргахыг ятгадаггүй, турхирдаггүй, эсхүл уриалдаггүй байх;

- (2) бусад агаарын хөлөг нь ICAO-гийн хүнд категорийн, эсхүл B757 агаарын хөлөг байх тохиолдолд, нислэгийн хөдөлгөөний удирдагч нь чөлөөлөгдөх хүсэлт гаргасан бусад категори, эсхүл маягийн агаарын хөлгийн нисгэгчид сануулдаг байх.

### **172.293. Идэвхтэй байгаа тусгай зориулалтаар ашиглах агаарын зайн зайчлал**

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, 172.79-д шаардсан зайчлалыг тогтоох үед тухайн минимум зайчлал нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) агаарын хөлөг нь идэвхтэй байгаа тусгай зориулалтаар ашиглах агаарын зайд IMC нөхцөлд үйл ажиллагаа гүйцэтгэж болох тохиолдолд:
- (i) нислэгийн түвшин 8850 м-ээс (FL290) хүртэл, 300 м-ийн (1000 ft) босоо зайчлал; эсхүл
  - (ii) нислэгийн түвшин 8850 м-ээс (FL290) дээш, 600 м-ийн (2000 ft) босоо зайчлал; эсхүл
  - (iii) НХҮ-ний ажиглалтын үйлчилгээгээр хангахдаа 9.3 км-ийн (5 NM) зайчлал; эсхүл
- (2) агаарын хөлөг нь идэвхтэй байгаа тусгай зориулалтаар ашиглах агаарын зайд VMC нөхцөлд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа тохиолдолд:
- (i) нислэгийн түвшин 8850 м-ээс (FL290) хүртэл, 150 м-ийн (500 ft) босоо зайчлал; эсхүл
  - (ii) нислэгийн түвшин 8850 м-ээс (FL290) дээш, 300 м-ийн (1000 ft) босоо зайчлал; эсхүл
  - (iii) НХҮ-ний ажиглалтын системээр хангахдаа 1.8 км-ийн (1 NM) зайчлал дээр нэмж ажиглалтын нарийвчлалын зөвшөөрөгдөх хэмжээ; эсхүл
- (3) дараах минима, эсхүл хэрэглэлийн нислэгийн журам ашиглан тогтоосон байх:
- (i) ИНД-173-ын дагуу олгосон ХНЖҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн баталсан; эсхүл
  - (ii) *хамааралгүй*
  - (iii) энэ зүйлийн (а)(1), (2), эсхүл (3)-т заасан зайчлалын минимум, эсхүл журам байхгүй тохиолдолд хяналттай нислэгийг, идэвхтэй байгаа тусгай зориулалтаар ашиглах агаарын зайнаас зай барьж хадгалснаар зайчлалыг хангах ёстой.

## **F Бүлэг - Стандарт хэвшмэл хэллэг**

### **172.351. Хамрах хүрээ**

(а) Энэ Бүлэг нь 172.105-ын шаардлагын дагуу тогтоосон, тодорхой нөхцөлд хэрэглэх стандарт хэвшмэл хэллэгийг тогтооно.

(b) Энэ Бүлэгт, хаалтад байгаа үг нь тохирох үгийг оруулах шаардлагатай болохыг, ташуу зураас нь ташуу зураасаар тусгаарлагдсан нөөц сонголтоос сонгох шаардлагатай болохыг харуулна.

**172.353. Нислэгийн хөдөлгөөний удирдагч болон нисгэгч хоорондын хэвшмэл хэллэг****(а) Нислэгийн зам, эсхүл аяллын түвшин боломжгүй тохиолдолд**

Тухайн нислэгт хүссэн нислэгийн зам, эсхүл аяллын түвшнийг зөвшөөрөх боломжгүй тохиолдолд:

“(нислэгийн зам ба/эсхүл түвшин) NOT AVAILABLE DUE (шалтгаан)”

**(b) Блок түвшин хүсэхэд**

- (1) Блок түвшнийг зөвшөөрөх тохиолдолд:  
“MAINTAINBLOCK (түвшин) TO (түвшин)”
- (2) Блок түвшнийг цуцлах тохиолдолд:  
“CANCEL BLOCK CLEARANCE...”

**(c) DME өндөр авах болон өндөр алдахад**

- (1) DME шаталсан өндөр авах журмыг зөвшөөрөх тохиолдолд:  
“CLIMB ABOVE DME STEPS” эсхүл “CLIMB ABOVE VORSEC DME STEPS”
- (2) DME шаталсан өндөр алдах журмыг зөвшөөрөх тохиолдолд:  
“DESCEND DME STEPS TO (түвшин)” эсхүл  
“DESCEND VORSEC DME STEPS TO (түвшин)”

**(d) Ил хараагаар нисэн гарахад**

Ил хараагаар нисэн гарахыг зөвшөөрөх тохиолдолд:

“VISUAL DEPARTURE”

**(e) Хүлээлтийг хүсэхэд**

Заасан газарзүйн байрлалд нэгээс олон хүлээх бүсийг хэвлэн нийтэлсэн бол, хүлээх зааварчилгаа өгөх тохиолдолд:

“HOLD AT (оноосон нэр). ENTER THE (тодорхойлогч) HOLDING PATTERN”

**(f) Анхааруулах хүлээлтийг хүсэхэд**

Агаарын хөлөг тогтоосон хүлээх цэгт хүрэхээс өмнө тухайн зааварчилгааг цуцалж болзошгүй үед, Монгол Улсын агаарын тээвэрлэгчид хүлээх зааварчилгаа өгөх тохиолдолд:

“PRECAUTIONARY HOLD”

**(g) ХБЗ-ны үйл ажиллагаанд**

- (1) Зогсох болон буулт үйлдэхийг зөвшөөрөх тохиолдолд:  
“CLEARED STOP AND GO”
- (2) Буулт үйлдэхэд ашиглах ХБЗ-ыг тодотгон заах тохиолдолд:  
“RUNWAY (ХБЗ-ны оноосон нэр) CLEARED TO LAND”
- (3) Хурдавчилсан хөөрөлт үйлдэх шаардлагатай тохиолдолд:  
“CLEARED IMMEDIATE TAKE-OFF”

**(h) Буулт үйлдэн, богино хүлээх үйл ажиллагаанд**

Агаарын хөлгийг ХБЗ-ны боломжит уртаас богино зайд буултын дараах гүйлтийг зогсоохыг шаардах тохиолдолд:

“LAND AND HOLD SHORT BY (явгалах зам, эсхүл бусад тогтоосон цэгээр)”

**(i) Ил хараагаар зайчлахад**

Бусад агаарын хөлгөөс ил харааны зайчлал хадгалахыг нисгэгчээс шаардах тохиолдолд:

“MAINTAIN VISUAL SEPARATION FROM (агаарын хөлөг) TO/UNTIL (зөвшөөрлийн хязгаар)”

**(j) Бартаа давах зайд**

(1) Нисгэгчид, өндөр алдах зөвшөөрөл нь радарын газрын бартааны зургийн хаялбарт суурилсан болохыг товчлол ашиглан мэдээлэх тохиолдолд:

“... RADAR TERRAIN”

(2) Бартааг давах зайг өөрөө зохицуулахыг нисгэгчээс шаардах тохиолдолд:

“MAINTAIN TERRAIN CLEARANCE VISUALLY”

**(k) Хууль бус үйлдлийг бататгахад**

SSR transponder Mode A code 7500-ыг зориуд өгсөн болохыг бататгах тохиолдолд:

“CONFIRMSQUAWKING 7500”

**(l) Нисдэг тэрэгний үйл ажиллагаанд**

Хяналттай аэродромд, гэхдээ тухайн маневрын талбайгаас гадна нисдэг тэрэгний үйл ажиллагааг зөвшөөрөх тохиолдолд:

“LAND/TAKEOFF/AIR TAXI AT YOUR DISCRETION”

**(m) Нислэгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зөвлөмж өгөхөд**

Нислэгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зөвлөмж хүсэх, эсхүл тухайн хүсэлтэд хариулах тохиолдолд:

“SUGGEST ....”

**(n) Нислэгийн хөдөлгөөний мэдээлэл өгөхөд**

IFR-ийн нислэгийн хөдөлгөөний мэдээлэл байхгүй тохиолдолд:

“NO REPORTED IFR TRAFFIC”

**(o) Хөдөлгөөний хайрцагт нэгдэхэд**

(1) Агаарын хөлөгт, стандарт хайрцагт нэгдэх журмыг хэрэгжүүлэх зааварчилгаа өгөх тохиолдолд:

“MAKE STANDARD OVERHEAD JOIN”

(2) Агаарын хөлөгт, тухайн аэродром дээгүүр нисэн өнгөрөөд, хайрцагт нэгдэх тусгай зааварчилгаа өгөх тохиолдолд:

“CROSS OVERHEAD, JOIN (тусгай зааварчилга)”

**172.355. НХУ-ний зохицуулалтын хэвшмэл хэллэг****(a) Аэродромын удирдлагад зааварчилгаа өгөхөд**

(1) Хязгаарлалт байхгүй тохиолдолд:

“RELEASED”

(2) Тухайн агаарын хөлөг газарт хүлээх шаардлагатай тохиолдолд:

“HOLD”

(3) Зөвшөөрөл нь тодорхой цагтай байх тохиолдолд:

“CLEARANCE VALID/EXPIRES AT (цаг)”



- (4) Зөвшөөрөл нь тодорхой цаг хугацааны үечлэлд суурилсан тохиолдолд:  
“RELEASED (минутын тоо) MINUTES BEHIND (эхний агаарын хөлөг)”
- (5) Зөвшөөрөл нь босоо зайчлал ашиглахад суурилсан тохиолдолд:  
“RELEASED AFTER (эхний агаарын хөлгийн дуудлага) HAS PASSED (түвшин)”
- (6) Зөвшөөрөл нь, заасан нислэгийн хөдөлгөөнөөс зайчлалаар хангадаг аэродромын хөдөлгөөний удирдлагад хамааралтай тохиолдолд: RYS гэж “Released, your separation”-ыг ойлгоно:  
“RYS (зөрчилдөж байгаа нислэгийн хөдөлгөөнд оролцож агаарын хөлгийн дуудлага) (хэрэв аль хэдийн өнгөрөөгүй бол, зөрчилдөж байгаа нислэгийн хөдөлгөөнд оролцож агаарын хөлгийн дэлгэрэнгүй мэдээлэл)”

**(b) Зайчлалаар хангах хариуцлагыг тодотгоход**

Зайчлалыг тогтоох, эсхүл хэн зайчлалаар хангаж байгааг тодруулах болон зохицуулалтыг мэдэгдэх тохиолдолд:

“MYSEPARATION/YOUR SEPARATION (зөрчилдөж байгаа нислэгийн хөдөлгөөнд оролцож агаарын хөлгийн дуудлага)”

**(c) Ажиглалтын хөдөлгөөний удирдагч хоорондын зохицуулалтад**

- (1) Хяналтыг шилжүүлэхэд нөлөөлөх тохиолдолд:  
“RELEASE (дэлгэрэнгүй мэдээлэл)”
- (2) Зөвхөн таньж тогтоох ажиллагааг шилжүүлсэн тохиолдолд:  
“IDENT (дэлгэрэнгүй мэдээлэл)”

**(d) Тооцоот мэдээний өөрчлөлтийг зөвшилцөхөд**

- (1) Шилжүүлж байгаа нислэгийн хөдөлгөөний удирдагчийн санаачилгаар:  
“WILL YOU ACCEPT (дэлгэрэнгүй мэдээлэл)”
- (2) Хүлээн авч байгаа нислэгийн хөдөлгөөний удирдагч татгалзах:  
“NEGATIVE, WILL ACCEPT (өөрийн санал болгосон дэлгэрэнгүй мэдээлэл)”

## **Г Бүлэг - НХҮ-ний ажиглалтын журам**

### **172.401. Транспондерийн түвшний мэдээллийг бататгах**

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, аэродромын удирдлагын нислэгийн хөдөлгөөний ажиглалтын дэлгэцэд тухайн агаарын хөлөг аэродромын өндөрлөгөөс дээш өндөр авч байгааг харуулж байгаа тохиолдолд, аэродромын удирдлага нь нисэн гарч байгаа агаарын хөлгийн транспондерийн түвшний мэдээллийг бататгаж болно.

(b) Дэлгэцэд үзүүлж байгаа түвшин нь хөөрөлтийн гүйлтийн үеийн тухайн аэродромын өндөрлөгөөс 90 м-ээс (300 ft) илүү зөрүүтэй үзүүлж байгаа тохиолдолд транспондерийн түвшний мэдээллийг ашиглаж болохгүй.

### **172.403. Хурдны хяналт**

Төгсгөлийн ойртолтын үед ХБЗ-ны босгоноос 7.4 км (4 nm) зайтай цэгийг өнгөрснөөс хойш хурдны хяналтыг хийхгүй, эсхүл үргэлжлүүлэхгүй байх ёстой.

## Н Бүлэг - Шилжилтийн зохицуулалт

### 172.451. НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилт

(а) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:

- (1) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч;
- (2) НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.

(b) Энэ зүйлд хамаарах байгууллага нь, энэ зүйлийн (е)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө дараах заалтыг мөрдөх шаардлагагүй:

- (1) 172.51(a)(2)(ii), хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;
- (2) 172.123, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх болон мөрдөхийн оронд, 172.453-ыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;
- (3) 172.125(a)(1A)(i);
- (4) 172.125(a)(3)(ii);
- (5) 172.125(a)(9).

(c) НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч болон НХҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг 2020 оны 4 сарын 1-нээс өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:

- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон хугацааг багтаасан байх;
- (2) тухайн байгууллага 172.123-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол Дарга:

- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
- (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн хугацааг тогтооно.

(f) Энэ зүйлийн (е)(2)-ын дагуу хугацааг тогтоохдоо Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
- (2) тухайн байгууллагын төвөгшил;
- (3) тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;
- (4) гэрчилгээг сунгах хугацаа;
- (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;
- (6) хэрэгжүүлэлтийн хугацаа нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.

(g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргахгүй байж болно.

(h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

### **172.453. НХҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт**

(a) Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор 172.451(b)(1)(ii)-т шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн байх ёстой.

(b) Дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоо нь дараах журмыг багтаасан байх ёстой:

- (1) аюулгүй байдлын бодлого болон аюулгүй байдлын бодлогын журам;
- (2) тухайн тогтолцоонд оршин байгаа хүндрэлтэй асуудал, эсхүл хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг тогтоох зорилгоор радио, утсан холбооны бичлэг, гэмтэл, зөрчлийн тайлан болон ажилтан, үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг багтаасан, чанарын үзүүлэлтэд мониторинг хийдэг байхыг бататгах журам;
- (3) тухайн тогтолцооны хүрээнд илрүүлсэн хүндрэлтэй асуудлыг залруулсан болохыг бататгах, залруулах арга хэмжээний журам;
- (4) тухайн тогтолцооны хүрээнд илрүүлсэн хүндрэлтэй асуудлын боломжит шалтгааныг арилгасан болохыг бататгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам;
- (5) хүсэлт гаргагчийн байгууллагын аюулгүй байдлын бодлогод нийцүүлэх зорилгоор аудит хийх дотоод аудитын хөтөлбөр;
- (6) энэ Дүрмийн шаардлагыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцооны байнгын тохиромжтой болон үр дүнтэй байдлыг бататгах удирдлагын дүгнэлт хийх журам.

(c) Аюулгүй байдлын бодлогын журам нь тухайн аюулгүй байдлын бодлогыг байгууллагын бүх түвшинд ойлгож, хэрэгжүүлж, мөрдөж байгааг бататгах ёстой.

(d) Залруулах арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:

- (1) оршиж байгаа хүндрэлтэй асуудлыг залруулах;
- (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах, залруулах арга хэмжээг эргэн хянах;
- (3) залруулах арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
- (4) залруулах арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.

(e) Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журамд дараах үйл ажиллагааг хэрхэн хийхийг заасан байх шаардлагатай:

- (1) хүндрэл үүсгэж болох асуудлыг залруулах;
- (2) тухайн арга хэмжээний үр дүнг бататгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эргэн хянах;
- (3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнд үндэслэн энэ Дүрмээр шаардсан журамд нэмэлт өөрчлөлт оруулах;
- (4) авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг удирдлага дүгнэх.

- (f) Чанарын дотоод аудитын хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) аудит хийх үйл ажиллагааны шинж чанарыг тооцож, аудит хийх байрлал болон давтамжийг тогтоодог байх;
  - (2) аудитыг тухайн үйл ажиллагаанд шууд хариуцлага хүлээдэггүй, сургалтад хамрагдсан аудитын ажилтан гүйцэтгэдэг болохыг бататгадаг байх;
  - (3) аудитын үр дүнг, аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтан болон дотоод аудит хариуцсан удирдах ажилтанд мэдээлдэг болохыг бататгадаг байх;
  - (4) хэрэв аудитаар хүндрэлтэй асуудал илэрсэн бол аудит хийгдсэн ажиллагааг хариуцсан ажилтнаас урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээ авахыг шаарддаг байх;
  - (5) авсан урьдчилан сэргийлэх, эсхүл залруулах арга хэмжээний үр дүнд дүгнэлт хийх зорилгоор эргэн хянах аудит хийдэг болохыг бататгадаг байх.
- (g) Удирдлагын дүгнэлт хийх журам нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) тухайн тогтолцооны байнгын үр дүнтэй байх хэрэгцээ шаардлагыг үндэслэн чанар баталгаажуулалтын тогтолцоонд удирдлагын дүгнэлт хийх давтамжийг тогтоодог байх;
  - (2) чанар баталгаажуулалтын тогтолцооны дүгнэлт хийх хариуцлага хүлээсэн ажилтныг тодорхойлдог байх;
  - (3) тухайн дүгнэлтийн үр дүнг дүгнэж, бүртгэл хөтөлдөг байхыг шаарддаг байх.
- (h) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь Ерөнхий зааварт заасан НХҮ-г аюулгүй хангахтай холбоотой асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцдаг байх үүрэгтэй.
- (i) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

--oOo--